



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/172

Улаанбаатар хот

Хүүхдийн эрх, хамгааллын статистик
үзүүлэлтийг тооцох аргачлал батлах тухай

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 7 дугаар заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2.Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нийгмийн статистикийн газар (Э.Эрдэнэсан)-т даалгасугай.

3.Батлагдсан аргачлалд тооцох боломжгүй үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэрийг бий болгох төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд (С.Зулпхар)-д зөвлөсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар (Ч.Баянчимэг)-т үүрэг болгосугай.


5.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/145 дугаар "Аргачлал батлах тухай" тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



В.БАТДАВАА

122623161061

Үндэсний статистикийн хорооны даргын
2022 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн
А/1.79 дугаар тушаалын хавсралт



ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ ТООЦОХ АРГАЧЛАЛ

АГУУЛГА

<u>АГУУЛГА</u>	2
<u>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</u>	3
<u>I Нийтлэг үндэслэл</u>	4
<u>II Хүүхдийн эрх, хамгааллын үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт</u> ...	5
<u>III Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үзүүлэлтийн хүрээ</u>	21
<u>IV Статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй</u>	25
<u>IV.1 Хүүхэд хамгааллын тогтолцоо</u>	25
<u>IV.2 Хүүхдийн эрхийн ерөнхий зарчмын үзүүлэлт</u>	27
<u>IV.3 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үзүүлэлт</u>	29
<u>IV.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээний үзүүлэлт</u>	33
<u>IV.5 Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал</u>	40
<u>IV.6 Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал</u>	55
<u>IV.7 Тусгай хамгааллын арга хэмжээний үзүүлэлт</u>	69
<u>IV.8 Хүүхдийн хууль зүйн үзүүлэлт</u>	73
<u>IV.9 Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал</u>	77
<u>IV.10 Гамшиг, гамшгийн онцгой байдлын үеийн үзүүлэлт</u>	79
<u>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</u>	81

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЗЦХ	Амьсгалын замын цочмог халдвар
АХС	Ажиллах хүчний судалгаа
БНХХИ	Бага насны хүүхдийн хөгжлийн индекс
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХСОУА	Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал
ДКУАТ	Дархлаажуулалтын кабинетын үйл ажиллагааны тайлан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖСХС	Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
КМ	Кейс менежмент
КУАТ	Кабинетын үйл ажиллагааны тайлан
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
НЭМХ	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУБТС	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр суралгаа
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ӨОУА	Өвчний олон улсын ангилал
СӨБ	Сургуулийн өмнөх байгууллага
ТАХТ	Төвлөрсөн асрамж халамжийн төв
ТАХҮ	Төвлөрсөн асрамж халамжийн үйлчилгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УГУ	Улаан бурхан, гахайн хавдар, улаанууд
УДШ	Улсын дээд шүүх
УОК	Улсын онцгой комисс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ХАХҮ	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХС	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
ХЭТК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭХ	Хүүхдийн эрхийн хороо
ХЭХТЗС	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох стратеги
ЦАС	Цаг ашиглалтын судалгаа
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭЗБТУАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газар нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасны дагуу Монгол Улсад хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилт, түүнтэй холбоотой 3 нэмэлт протоколуудын дүгнэлт зөвлөмжийг хэрхэн хангаж буй талаарх үндэсний тайлан илтгэлийг НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд өргөн барьдаг үүрэгтэй. Эдгээр тайлан, илтгэлийг үнэн бодит статистик тоо мэдээлэлд тулгуурлан, олон улсад харьцуулалт хийх боломж бүхий жишиг арга зүйн дагуу боловсруулах шаардлагатай.

Хүүхдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тусламж үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгааллын чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй үйлчилгээг хэнийг ч орхигдуулахгүйгээр, нийгмийн бүх хүрээнд үзүүлэх бодлого боловсруулах, үр дүнг үнэлэх, хяналт үнэлгээ, шинжилгээ хийх, төсөв төлөвлөлт боловсруулахад бодит статистик тоо мэдээлэл хэрэгтэй юм.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14.1.6, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.1.8, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1 болон Залуучуудын хөгжлийг дэмжих тухай зэрэг хуулиудад хүүхдийн эрх, хамгааллын талаар нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх тухай тусгасан.

Энэхүү аргачлалын зорилго нь хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтүүдийг тооцох, олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэн өөрийн улс орны онцлогийг тусгасан нэгдсэн ойлголт, арга зүйн мэдээллээр статистикийн мэдээлэл гаргагч болон хэрэглэгчийг хангах явдал юм.

Уг аргачлалд нийт 10 бүлгийн 169 үзүүлэлтийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийг тусгасан болно.

1. Хүүхэд хамгааллын тогтолцооны 8 үзүүлэлт
2. Хүүхдийн эрхийн ерөнхий зарчмын 6 үзүүлэлт
3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн 11 үзүүлэлт
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний 19 үзүүлэлт
5. Эрүүл мэндийн салбарын хүүхэд хамгааллын 47 үзүүлэлт
6. Боловсролын салбарын хүүхэд хамгааллын 41 үзүүлэлт
7. Тусгай хамгааллын арга хэмжээний 13 үзүүлэлт
8. Хүүхдийн хууль зүйн асуудалтай холбоотой 15 үзүүлэлт
9. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын 4 үзүүлэлт
10. Гамшиг, гамшгийн онцгой байдлын үеийн 5 үзүүлэлт

ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО	
1. Хүүхэд	18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. ¹
1. Хүүхэд хамгаалал	Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. ²
1. Хүүхэд хамгааллын байгууллага	Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн төв болон захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд хамгааллын байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, харьяа байгууллагууд болон хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, олон улсын байгууллага хуулийн этгээдийг хэлнэ.
1. Хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа	Хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах, хэрэгжүүлэх, тэднийг аливаа эрсдэл, хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх, хамгаалах бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээ нь олон талын оролцоог хангасан, уялдаа холбоотой байна. ³
1. Хүүхэд хамгааллын салбарын хүний нөөц	Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж буй тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцийг ойлгоно. Үүнд: 1. Хүүхдийн эрхийн улсын байцаагч 2. Хүүхэд хамгааллын мэргэжилтэн 3. Тусламжийн утасны хүний нөөц 4. Нэг цэгийн үйлчилгээний төвийн хүний нөөц 5. Түр хамгаалах байрны хүний нөөц 6. Халамж, асрамжийн газрын хүний нөөц 7. Боловсролын нийгмийн ажилтан 8. Эрүүл мэндийн нийгмийн ажилтан 9. Халамжийн нийгмийн ажилтан 10. Шүүхийн нийгмийн ажилтан 11. Баг, хорооны нийгмийн ажилтан 12. Хүүхдийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл авсан төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан
1. Нийгмийн ажилтан	Баг, хороо, сургууль, нийгмийн халамж, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг ойлгоно. ⁴
1. Мэргэшсэн нийгмийн ажилтан	Монгол Улсын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтод заасан 2635 кодтой Нийгмийн (мэргэшсэн) ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн, 2635-15 кодтой Нийгмийн ажилтан, хүүхэд, залуучуудын мэргэжилтэнг ойлгоно. ⁵
1. Улсын төсөв	Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг хэлнэ. ⁶
1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)	ДНБ нь улс орны хил хязгаарын дотор нэг жилийн хугацаанд эдийн засгийн болон нийгмийн үйлчилгээний хүрээнд шинээр бүтээгдсэн нэмэгдэл өртгийн нийлбэр юм. ⁷
1. Хүүхдийн эрхийн конвенцын зарчим	Хүүхдийн эрхийн конвенц нь ялгаварлан гадуурхахгүй байх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг эрхэмлэх, эсэн мэнд амьдрах, хөгжих орчинг хангах болон хүүхдийн үзэл бодлыг хүндлэх гэсэн үндсэн 4 зарчимтай байна. ⁸

1 Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1 дүгээр зүйл

2 Хүүхэд хамгааллын тухай хууль

3 Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг. 2018 оны 03 дугаар тогтоол

4 Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага. MNS 6949:2021

5 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт. ХНХЯ, 2008

6 Монгол Улсын Төсвийн тухай хууль, 4.1.6 дахь заалт

7 Дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох аргачлал. УСХ. 2017 он

8 Хүүхдийн эрхий тухай конвенц

1.	Хүүхдээс гарсан санал	Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх, хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох эрхтэй. ⁹
1.	Хүүхдийн төлөө зөвлөл	Хүүхдийн эрхийг хангах талаарх салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг хэлнэ.
2 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ		
2.	Үе тэнгийнхний дээрэлхэлт (хүчирхийлэл)	Нэг хүүхэд нөгөө хүүхдээ бие махбодын, эсвэл сэтгэл санааны дарамж үзүүлэх, айлган сүрдүүлэх, зодох, байнга дооглох, тохуурхах, гадуурхах, бүлэглэн гадуурхах, нэр хоч өгөх зэрэг үйлдлүүд болон цахимаар заналхийлэх, сүрдүүлэх, нэр төрийг нь гутаан доромжлох үзэгдэл хамаарна. ¹⁰
2.	Цахим дээрэлхэлт	Цахим дээрэлхэлт гэдэг нь хүүхдэд гомдохоор зурвас илгээж, бусдад харагдахаар цахим орчинд мэдээллийг тавих, цахим орчинд сүрдүүлэх, хэн нэгнээ гутаан доромжилсон цахим хуудас нээх, зөвшөөрөлгүйгээр мессеж, мэйл, нийгмийн харилцааны сайтууд болон бусад сувгуудаар хүүхдийн нэр төрд халтай дүрс зураг тавих, бусдад түгээх зэрэг орно.
2.	Санаатай аллагын гэмт хэргийн хохирогч	Хууль бусаар, санаатайгаар хүнийг үхэлд хүргэх эсвэл ноцтой гэмтэл учруулах гэмт үйлдлийн улмаас амь, насаараа хохирсон болох нь шүүхээр тогтоогдсон гэмт хэргийн хохирогчийг ойлгоно (НҮБ-ын ГХСОУА).
2.	Хүний эрхийн бие даасан механизм	Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс гэнэ. ¹¹
2.	Гомдол, нэхэмжлэл гаргах	Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжид заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргана. ¹²
2.	Төрсний бүртгэлд хугацаандаа хамрагдах	Эцэг, эх, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл эрх бүхий байгууллагын төлөөлөгч хүүхэд төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор холбогдох баримт бичгийг бүрдүүлж, төрсний бүртгэлд бүртгүүлнэ. ¹³
2.	Нас сэтгэхүй, танин мэдэхүйн хэрэгцээнд тохирсон ном	Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, насны онцлогт тохирсон цаасан болон бусад материал дээр хэвлэгдсэн тодорхой мэдээлэл агуулсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг ном гэж хэлнэ. ¹⁴
3. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ		
3.	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг ойлгоно. ¹⁵
3.	Бие махбодын хүчирхийлэл	Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед халдсаныг эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ. ¹⁶
3.	Бэлгийн хүчирхийлэл	Хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан, энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ. ¹⁶

9 Хүүхдийн эрхийн тухай хууль, 8 дугаар зүйл

10 Хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой нэр томъёо, ухагдахууны тайлбар толь. 844-р тайлбар. 2018

11 Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, 3 дугаар зүйл

12 Хүүхдийн эрхийн тухай хууль, 19 дүгээр зүйл

13 Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, 6.1 дэх заалт

14 Соёлын статистик үзүүлэлт тооцох аргачлал. УСХ. 2013 он

15 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4.1.8 дахь заалт

16 Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг. 2018 оны 03 дугаар тогтоол

3. Сэтгэл санааны хүчирхийлэл	Асран хамгаалагчийн зүгээс хүүхдийг үнэ цэнэгүй, согогтой, чамд хэн ч хайргүй, чамтай хамт байхыг хэн ч хүсэхгүй гэж ойлгуулах, айлган сүрдүүлэх, хэл амаар доромжлох, загнах, гутаах зэрэг үйлдэл юм. ¹⁶
3. Үл хайхрах	Зохистой хоол унд, хувцас, орон байр, эмнэлгийн тусламж боловсрол эзэмших зэрэг хүүхдийн үндсэн хэрэгцээг хангаж чадахгүй байхыг хэлнэ. ¹⁶
3. Бие махбодын хүчирхийлэл	Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх, зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед халдсаныг эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ. ¹⁶
3. Асран хамгаалагч	Хүүхдийг өөрийн гэр бүлдээ авч, түүний эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох, хамгаалуулах эрх болон хэрэгцээг ханган хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээгчийг хэлнэ. ¹⁷
3. Багш, сурган хүмүүжүүлэгч	Үндэсний стандартын дагуу сурган хүмүүжүүлэх арга, туршлага бүхий үр бүтээлтэй багшлах болон сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах чадвартай багш, сурган хүмүүжүүлэгч нарыг ойлгоно. ¹⁸
3. Хүн худалдаалах	Хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг ойлгоно. ¹⁹
3. Бэлгийн хүчирхийлэл	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулахыг хэлнэ. ¹⁶
3. Хамтран амьдрагч	Гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг хэлнэ. ²⁰
3. Гэр бүлийн хүчирхийлэл	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд (эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү) тухайн хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ. ²¹
3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүүхдийг ойлгоно. ²²
4 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан хүүхэд	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авхуулахаар хандсан хүүхдийг хэлнэ. ²³
4. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган

17 Хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой нэр томъёо, ухагдахууны тайлбар толь. 91-р тайлбар. 2018
18 Боловсролын салбарын статистик үзүүлэлт тооцох аргачлал. УСХ. 2013 он

19 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3.1.1 дэх заалт

20 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5.1.6 дахь заалт

21 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5.1.1 дэх заалт

22 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5.1.2 дахь заалт

23 Хүүхэд хамгааллын тухай хууль, 11.1 дэх заалт

	зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг хэлнэ. ²⁴
4. Хүүхдийн хувийн хэрэг (Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний)	Эцэг, эхийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа асран хамгаалагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн зүгээс хүүхдийн өсөлт хөгжил, зан төлөв, тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өөрчлөлтийг хянах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан бүртгэх, хөтлөх, хянах баримт бичгийн бүрдлийг ойлгоно. ²⁵
4. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ (ХАХҮ)	Эцэг, эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт болон богино хугацаагаар асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг хэлнэ. ²⁶ ХАХҮ-нд дараах үйлчилгээг хамруулж ойлгоно. • Төрөл садан хүний асрамж халамжид байгаа хүүхэд • Асралт гэр бүлийн асрамж халамжид байгаа хүүхэд • Хувилбарт асрамжийн төвүүдэд амьдарч байгаа хүүхэд
4. ХАХҮ-нд хамруулсан хүүхэд	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд дараах тохиолдолд хамруулна. Үүнд: • Эцэг, эх нь нас барсан • Шүүхээс эцэг эх нь нас барсан, сураггүй алга болсныг тогтоосон • Шүүхээс эцэг эх нь эрхзүйн чадамжгүйг тогтоосон • Эцэг эх байх эрхийг хассан • Эцэг эх байх үүргээ удаа дараа зөрчсөн • Эцэг эх нь хүүхдээ асран хамгаалах чадваргүй болсон • Эцэг эх нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн • Бусад
4. ХАХҮ-г зогсоосон хүүхэд	Үйлчилгээг дараах үндэслэлээр цуцална. • Гэрээ цуцлагдсан • Хүүхэд үрчлэгдсэн • Хүүхэд 18 нас хүрсэн • Гэр бүлдээ эргэж нэгдсэн • Бие даан амьдрах хяналтад шилжсэн • Хүүхэд нас барсан • Бусад
4. Нэг цэгийн үйлчилгээ	Хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг ойлгоно. ²⁷
4. Түр хамгаалах байр	Хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг ойлгоно. ²⁷
4. Төвлөрсөн асрамж халамж	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувийн болон улсын асрамжийн газар гэр бүлийн орчинд дүйцэхүйц, бүлгийн зохион байгуулалтын хэлбэрээр төвлөрүүлэн асрамжлах үйлчилгээг ойлгоно. ²⁸
4. Үрчлэлт	Үрчлэлт гэж үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдолд ойлгоно.
4. Улсын хилээр нэвтэрсэн хүүхэд	Тухайн жилд аялал жуулчлал, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад зорилгоор улсын хилээр гарсан, орсон Монгол Улсын харьяат хүүхдийг ойлгоно.
4. Хамтарсан багийн үйлчилгээ	Хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэтгэлзүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын үйлчилгээ болон холбон зуучлах үйлчилгээг хамтран үзүүлэх

24 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4.1.6 дахь заалт

25 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (4.19). MNS 5852:2017

26 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (4.5). MNS 5852:2017

27 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5.1.3, 5.1.5 дахь заалт

28 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (4.10). MNS 5852:2017

	сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг хэлнэ. ²⁹
4. Хагас болон бүтэн өнчин хүүхэд	"Хагас өнчин хүүхэд" гэж эцэг эсвэл эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, мөн эцэг, эх хоёрын аль нэг нь тогтоогдоогүй, нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй болсон 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ. "Бүтэн өнчин хүүхэд" гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.³⁰
5 ЭРҮҮЛ МЭНД	
5. Эмнэлгийн мэргэжилтэн	Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хүний их, шүдний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, сувилагч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэнг ойлгоно. ³¹
5. Амьд төрөлт	Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхсийг нь салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.
5. Өсвөр насны охид	10-19 насны охидыг хамааруулна.
5. Төрөлтийн нийлбэр коэффициент	Нэг эмэгтэйн (нөхөн үржихүйн амьдралын хугацаа дуустал нас барахгүй гэж үзвэл) нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоог илэрхийлнэ. Төрөлтийн нийлбэр коэффициентийг бүх эмэгтэйчүүдийн тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн нэг эмэгтэйд ногдохоор тооцдог. ³²
5. Хугацаандаа төрөлт	Жирэмсний 37-42 бүтэн долоо хоног (259-293 хоног) хүртэлх хугацаанд төрсөн төрөлтийг ойлгоно.
5. Үр хөндөлт	Жирэмсний 22 долоо хоног хүртэл хугацаанд эмнэлгийн цэвэр, ая тухтай орчинд жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах мэс ажилбарыг хэлнэ.
5. Гэрлэлт	Гэрлэлт гэж хуулиар тогтоогдсон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг ойлгоно. ³³
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ. ³⁴
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 16 төрлийн тусламж, хөнгөлөлт үзүүлнэ. ³⁵
5. Байнгын асаргаа, шаардлагатай иргэн	Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхдийг ойлгоно. ³⁶

29 Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хууль, 5.1.4 дэх заалт
30 Нийгмийн халамжийн тухай хууль, 3.1.7 дахь заалт
31 Эрүүл мэндийн тухай хууль, 3.1.5 дахь заалт
32 Эрүүл мэндийн статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, 2021 он
33 Гэр бүлийн тухай хууль, 3.1.1 дүгээр заалт
34 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 4.1.1 дэх заалт
35 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 26 дугаар зүйл
36 Нийгмийн халамжийн тухай хууль, 3.1.6 дахь зүйл

5. Сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэг	Сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй гэж сэтгэцийн эмгэг, хоёр туйлт сэтгэл хөдлөлийн эмгэг, дунд-хүнд сэтгэлийн хямралыг хэлнэ. ³²
5. Цахим тоглоомд донтох	Цахим тоглоомд донтсон гэж хүүхэд сонирхол хүсэлдээ автан цахим ертөнц болон тоглоомыг цаг хязгааргүй ашигласнаар хүүхдийн сэтгэц, зан үйлд илэрч буй эмгэг шинжийг ойлгоно. ³²
5. Архи, согтууруулах ундааны хэрэглээ	Нэг уулт нь нэг лааз эсвэл нэг шил шар айраг, эсвэл нэг дарсны хундага дарс, эсвэл нэг хундага архи, коньяк, виски зэрэг согтууруулах ундаа уусныг ойлгоно.
5. Тамхи	Татах, үнэрлэх захлах зорилгоор тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн хэрэглээний бүтээгдэхүүнийг "тамхин бүтээгдэхүүн" гэнэ. Тамхи нь утаат болон утаагүй хэлбэртэй байна.
5. Утаат тамхи	Үйлдвэрийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг утаат тамхи гэнэ. ³⁷
5. Утаагүй тамхи	Утаа гаргадгаас бусад төрлийн тамхи болон тамхин бүтээгдэхүүнүүдийг "утаагүй тамхи" гэнэ. Үүнд: зажилдаг, үнэрлэдэг, шүд буйлны завсар хийдэг эсвэл арьсанд түрхдэг зэрэг багтана. Бүх утаагүй тамхинд никотин агуулагддаг. Утаагүй тамхи нь төрөл бүрийн хэлбэрээр үйлдвэрлэгддэг. Жишээ нь: зажилдаг бохь, хамрын тамхи, уусдаг тамхин бүтээгдэхүүн, электрон тамхи гэх мэт.
5. Мансууруулах бодис хэрэглэх эмгэг	Согтууруулах ундаа болон/эсвэл хар тамхи давтан хэрэглэсний улмаас үүссэн өвчин, эмгэг, хөдөлмөрийн чадвар алдалт, ажил/сургууль завсардалт зэрэг эмнэлзүйн ба үйл ажиллагааны алдагдлыг хэлнэ. Мансууруулах бодис хэрэглэдэг сурагч гэж сүүлийн нэг сард 1, түүнээс олон удаа марихуана, каннабис, хашиш зэрэг мансууруулах бодис хэрэглэснийг ойлгоно.
5. Түлэгдэлт	Арьсны бүх эсвэл аль нэг давхаргын эд эс нь халуун болон химийн үйлчлэлээр гэмтэх, түлэгдэхийг ойлгоно.
5. Осол гэмтэл	Осол гэмтэл гэж гадны хүчин зүйлийн үйлчлэл, нөлөөллөөр хүний бие махбод, эрүүл мэндэд учрах хохирлыг хэлнэ.
5. Амиа хорлох	Гэмтээх, хордуулах, боомилох зэргээр тухайн этгээд үхэх зорилгоо илэрхий байдлаар эсвэл далд хэлбэрээр ямар нэгэн нотолгоотойгоор өөрийгөө егүүтгэх үзэгдлийг хэлнэ. ӨОУА-10-ын Х60-Х84, Y87.0 кодтой өвчний шалтгаант нас баралт орно. ³⁸
5. Зам тээврийн осол	Зам, тээврийн ослын шалтгаант нас баралтад ӨОУА-10-ын V01-V99 кодтой нас баралт орно. ³⁸ Зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно.
5. Нярайн эрт үеийн эндэгдэл	Төрсний дараа эхний 7 хоног хүртэлх хугацаанд нас барахыг нярайн эрт үеийн эндэгдэл гэнэ.
5. Нярайн хожуу үеийн эндэгдэл	Төрсний дараа 7 хоногоос 28 хүртэлх хоногийн хугацаанд нас барахыг нярайн хожуу үеийн эндэгдэл гэнэ.
5. Нярайн эндэгдэл	Төрсний дараах 28 хоног хүртэлх хугацаанд нас барахыг нярайн эндэгдэл гэнэ.
5. Нялхсын эндэгдэл	0-364 хоногтой нас барахыг нялхсын эндэгдэл гэнэ.
5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0-59 сартай нас барахыг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гэнэ.
5. Эхийн эндэгдэл	Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоотой шалтгаанаар эндсэн эндэгдэл юм.

37 Тамхины хяналтын тухай хууль, 3.1.2 дахь заалт

38 Энвүл мэндийн статистикийн үзүүлэлт тооцох аргачлал. YCX. 2021 он

5. Туранхай хүүхэд	Өндөрт харьцуулсан жин нь жишиг хүн амын голчоос доош хоёроос илүү стандарт хазайлтаар их байвал туранхай гэж үздэг. Туранхай нь ихэвчлэн эрдэс, илчлэгийн болон өвчлөлөөс шалтгаалдаг.
5. Илүүдэл жинтэй хүүхэд	Өндөрт харьцуулсан жин нь жишиг хүн амын голчоос дээш хоёроос илүү стандарт хазайлтаар их байвал дунд болон хүнд хэлбэрийн илүүдэл жинтэй гэж үзнэ.
5. Өсөлтийн хоцролттой хүүхэд	Насанд харьцуулсан өндөр нь жишиг хүн амын голчоос доош хоёроос илүү стандарт хазайлтаар их байвал өсөлт хоцрогдолтой гэж үздэг. Өсөлт хоцрогдол буюу хоол тэжээлийн архаг дутал нь амьдралынхаа эхэн үеэс эхлэн урт хугацааны турш хангалттай хоол тэжээл авч чадаагүй, ойр ойрхон өвддөг эсвэл архаг өвчтэй зэрэг шалтгаанаас бий болдог. Хүүхдийн хоол тэжээлийн дутлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан жишиг хүн амын үзүүлэлтийг ашиглан тооцно. Хоол тэжээлийн байдлын насанд харьцуулсан жин, насанд харьцуулсан өндөр, өндөрт харьцуулсан жин гэсэн 3 хэмжүүрийг жишиг хүн амын үзүүлэлтийн голчоос хазайх стандарт хазайлтын нэгжээр (z оноо) илэрхийлж болно. ³⁸
5. Дархлаажуулалтын үндэсний товллол	Улс орны хэмжээнд заавал хийх дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн нас, цаг хугацааны товыг хэлнэ. Заавал хийх дархлаажуулалтын товллолд дараах вакциныг хийхээр заасан. Үүнд: Сүрьеэ: Төрснөөс хойш 24 цагийн дотор Хепатит Б: Төрснөөс хойш 24 цагийн дотор Халдварт саа: Төрснөөс хойш 24 цагийн дотор, 2, 3, 4 сартайд нийт 4 тун Тавт (хөхүүл ханиад, сахуу, татран, хепатит Б, хемофлюс инфлюэнза Б): 2, 3, 4 сартайд нийт 3 тун УГУ (улаанбурхан, гахайн хавдар, улаанууд): 9 сартайд, 2 настайд нийт 2 тун Хепатит А: 14 сартайд, 2 настайд нийт 2 тун
5. Хүүхдийн идэвхтэй хяналт	Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан "15 хүртэлх насны эрүүл хүүхдийг өрхийн эмч идэвхтэй хянах үлгэрчилсэн загвар"-ын дагуу хүүхдийг төрсний дараа 2 сар хүртэл 7 хоног тутам, 2 сараас 12 сар хүртэл сар тутам үзэж, улирал тутам үечилсэн дүгнэлт бичихийг хэлнэ.
5. Жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгсэл	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга: Жирэмслэхээс сэргийлэх эм, суулгац, тариа, ерөндөг, эрэгтэй ба эмэгтэй бэлгэвч, эрэгтэй ба эмэгтэй стерилизаци. Жирэмслэхээс сэргийлэх уламжлалт арга: хуанлийн арга, гадуур тавих арга.
5. Их эмч	Монгол Улсын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтод заасан 221 кодтой хүний эмч, 2211 кодтой ерөнхий мэргэжлийн эмч, 2212-18 кодтой хүүхдийн их эмчийг ойлгоно. ³⁹
5. Бага жинтэй төрөлт	2500 граммаас бага жинтэй төрөлтийг хэлнэ.
5. ХДХВ/ДОХ	Хүний дархлал хомсдолын вирус /ХДХВ/-ээр үүсгэгддэг хам шинж. Энэ үед бие махбодын дархлалын тогтолцоо хүндээр гэмтсэнээс эрүүл хүнд өвчин үүсгэдэггүй нянгийн шалтгаантай халдвар олноор илэрдэг. ⁴⁰
5. Гадаад орчны агаарын чанар	Агаар дахь түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшний хэмжээгээр хэмжинэ. Гадаад орчны агаарын бохирдлыг хэмжих гол хэмжүүр нь нарийн (PM25) болон том (PM10) ширхэглэгт тоосонцрын хэмжээ бөгөөд өдөр бүрийн агаарт ялгарсан хэмжээнээс жилийн дунджийг тооцож, хүн амын жингээр жинлэн нэг куб метр агаарт ногдох микрограмм (мг/м3)-аар илэрхийлнэ. Мөн том ширхэгт тоосонцор

	(PM10)-ыг жижиг (PM2.5) болгон хэмжихэд 0.3-0.8 утга бүхий хөрвүүлэгч хүчин зүйл ашигладаг. ⁴¹
5. Дотоод орчны агаарын чанар	Дотоод орчны агаарын чанарыг хэмжих химийн гол бохирдуулагч нь нүүрсхүчлийн хий, радон, формальдегид болон агаарын исэлдэх чанарыг нэг куб метр агаарт ногдох микрограмм (мг/м3)-аар илэрхийлнэ. ⁴¹
5. Агаарын бохирдолтой холбоотой өвчлөл	Агаарын бохирдолтой холбоотой өвчлөлд дараах өвчлөл орно. Үүнд: - Бага насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдвар (5 хүртэлх насны); - Насанд хүрэгчдийн тархины судасны өвчин (цус харвалт) (25 -аас дээш насны); - Насанд хүрэгчдийн зүрхний ишемийн өвчин (25-аас дээш насны); - Насанд хүрэгчдийн уушгины архаг бөглөрөлт өвчин (25 -аас дээш насны); - Насанд хүрэгчдийн уушгины хорт хавдар (25 -аас дээш насны).
6 БОЛОВСРОЛ	
6. Бага насны хүүхдийн хөгжлийн индекс	Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (БНХХИ)-ийг НҮТС-ны үр дүнгээс тооцдог бөгөөд 14 зүйл бүхий модуль асуулт, хоёр тусдаа аргачлалыг ашиглана. Тус модулийн 10 асуултыг ОУБТС-ны стандарт аргачлалд заасны дагуу, харин үлдсэн 4 асуултыг Монгол Улсын Сургуулийн Өмнөх Боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасны дагуу БНХХИ тооцоход тус тус ашигласан. Олон улсын аргачлалын дагуу ОУБТС-ны стандарт асуултаар хөгжлийн явцыг үнэлнэ. Үүнд: Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар: Цагаан толгойн 10-аас доошгүй үсгийг таньж, нэрлэж чаддаг, 4-өөс доошгүй энгийн түгээмэл үгийг уншдаг, 1-10 хүртэл тоог таньж, нэрлэж чаддаг эсэхээр хөгжлийн зохих түвшинд байгаа эсэхийг тодорхойлох бөгөөд наад зах нь 2-ыг чаддаг бол чадвар нь зохих түвшинд байна гэж үзнэ. Бие бялдрын хөгжил: Хүүхэд аливаа зүйлийг (мод, чулуу гэх мэт) 2 хуруугаараа барьж чаддаг, мөн хүүхэд тоглохоос дургүйцдэггүй бол тухайн хүүхэд бие бялдрын хөгжлийн зохих түвшинд байна гэж үзнэ. Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар: Хүүхэд бусад хүүхдүүдтэй эвтэй, зөв харилцдаг, бусдыг цохиж, өшиглөж, хаздаггүй, мөн хүүхдийн анхаарал амархан сарнидаггүй гэсэн 3 үзүүлэлтээс наад зах нь 2 чадвар тухайн хүүхдэд байвал хөгжлийн зохих түвшинд байна гэж үзнэ. Сурах чадвар: Хүүхэд энгийн зааврын дагуу ямар нэгэн зүйлийг зөв хийж, мөн хийлгэх гэж өгсөн зүйлийг зөв бөгөөд бие даан хийж, гүйцэтгэж байвал сурах чадвар нь зохих түвшинд байна гэж үзнэ. Монгол Улсын Сургуулийн Өмнөх Боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасны дагуу дараах асуултаар БНХХИ-ийг тооцно. Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадамж: Хэрвээ хүүхэд өнгө таньж, ялгаж чаддаг, гурвалжин, дөрвөлжин, дугуй зэрэг энгийн дүрсийг таньж ялгадаг, 1-10 хүртэлх цифрийг нэрлэж, таньж чаддаг бол тус чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзнэ. Бие бялдрын хөгжил: ОУБТС-ны стандарт 2 асуулт болох "Хүүхэд жижиг юмыг 2 хуруугаараа чимхэж авч чаддаг уу?", "Хүүхэд тоглохоос дургүйцэж бие нь тавгүйрхэж, сульддаг уу?" гэсэн асуултуудаас гадна эрхий, долоовор, дунд хуруугаараа халбага, сэрээ, үзэг, харандаа зэргийг барьж чаддаг бол хөгжил нь зохих түвшиндээ байна гэж үзнэ.
6. ЕБС-ийн хамран сургалтын цэвэр жин	Боловсролын тухайн түвшинд албан ёсоор суралцах насандаа элссэн суралцагчдын тооны тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувиар хамран сургалтын цэвэр жинг тодорхойлно. Энэ үзүүлэлтийн дээд хэмжээ онолын хувьд 100 хувь байна. Энэ үзүүлэлтийг тооцохдоо боловсролын бүх байгууллагыг бүрэн хамарсан мэдээлэлд үндэслэх ёстой. Анхан болон дунд шатны боловсролын тухайд хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо дараах нөхцөлийг анхаарах хэрэгтэй. Үүнд: 1. Бага боловсролд элсэх албан ёсны өдөр бага боловсролын түвшинд элсвэл зохих бүх хүмүүсийн төрсөн өдөртэй ижил биш байх; 2. Зарим хүүхэд бага сургуульд зохих наснаасаа эрт элсэж, тэр чигээрээ энэ шатны

	боловсролыг эрт эзэмшдэг; 3. Бага боловсролд элсэх нас өөрчлөгдсөн боловч суралцах хугацаа нь өөрчлөгдөөгүй байж болно.
6. Боловсролын агуулга	Зохион байгуулалттай сургалт гэдэг нь боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, төлөвшлийн цогц юм. Үүний жишээ нь бага насны хүүхдийн /сургуулийн өмнөх/ болон бага сургуулийн боловсролын түвшний сургалт юм. Бага насны хүүхдийн боловсрол нь нэгдмэл арга зүйн тусламжтайгаар хүүхдийн танин мэдэхүй, бие бялдар, нийгэм, эмоци хөгжлийг дэмжих, бага насны хүүхдийг гэр бүлийн хүрээнээс гадуур зохион байгуулагдсан заах үйлтэй танилцуулахад чиглэгдэнэ. (Боловсролын ОУ-ын стандарт ангиллын түвшин 0) Бага сургуулийн боловсрол нь суралцагчдад унших, бичих, математикийн (бичиг үсэг, тоо бодлого) суурь чадвар эзэмшүүлэх, мэдлэгийн үндсэн салбарууд, хувь хүний болон нийгмийн хөгжлийг ойлгох, суралцах үндэс суурийг бүрэлдүүлэх, дунд боловсрол эзэмшихэд бэлтгэхэд чиглэгдэнэ (Боловсролын ОУ-ын стандарт ангиллын түвшин 1). Анх сургуульд элсэх албан ёсны нас гэдэг үндэсний хууль тогтоомж, бодлогын хүрээнд тогтоосон нас юм.
6. СӨБ-ын багш	Энэ үзүүлэлтийг тооцоход цагийн багш, хичээлийн ээлжийн тоо, олон анги нийлүүлсэн анги гэх мэт олон хүчин зүйл байгааг анхаарах хэрэгтэй. Цагийн багш нарыг үндсэн багшид хөрвүүлэн тооцно. Багш нарын тоонд сургалтын үйл ажиллагаанд оролцож байгаа бүх багшийг оролцуулна.
6. ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	ЕБС-д суралцаж байгаа 6-17 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор оношлогдсон 6-17 насны хүүхэд.
6. СӨБ-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор оношлогдсон 2-5 насны хүүхэд.
6. Сургуулийн гадна байгаа хүүхэд	Сургуулийн гадна байгаа хүүхэд гэж сургуулийн насны боловч албан ёсоор сургуульд огт хамрагдаагүй хүүхдийг ойлгоно.
6. Хичээлээс гадуурх сургалтын ажил	Суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас сонирхлыг гүнзгийрүүлж хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ
6. Ариун цэврийн байгууламж	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байр нь бохир ус зайлуулах төвлөрсөн системд холбогдсон байна. ЕБС-ийн 1 ээлжинд хичээллэх 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур, 1 шээлтүүр, бага ангийн 30 хүүхдэд 1 суултуур тус тус байхаар төлөвлөнө. Цэцэрлэгийн хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөний угаагуур, суултуур нь 2-3, 4-5 гэсэн ангилалтай байна. ⁴²
6. Боловсролын үзүүлэлтээр тооцсон "Тэгш байдлын" индекс	Боловсролын үзүүлэлтээр тооцсон тэгш байдлын индекс нь тухайн үзүүлэлтийн бүлэг (үүнд хүйс, байршил, аж байдлын түвшин) доторх утгыг хооронд нь харьцуулж, тухайн бүлэг доторх тэнцвэрийг илэрхийлэх ба утга нь 1 байвал тэгш байдал хангагдсан, 1-ээс их, бага бол ялгаатай байгааг харуулна. Индексийг тооцоход боловсролын тухайн үзүүлэлтийг харьцуулалтаар буюу хүйс, суурьшил, аж байдлын түвшнээр дэлгэрүүлж тооцсон байх шаардлагатай. ⁴³
6. Суралцаагүй, хөдөлмөр эрхлээгүй, сургалтад	Ажил хийгээгүй болон суралцаагүй өсвөр насны хүүхэд гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, албан боловсрол эзэмших сургуульд суралцаагүй, бүх шатны сургалтад хамрагдаагүй байгаа 15-17 насны ажилгүй болон ажиллах хүчнээс гадуурх хүүхдийг ойлгоно. ⁴⁴

42 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага. MNS 6799. 2019

43 ТХЗ-ын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. ҮСХ. 2021 он

44 ТХЗ-ын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. ҮСХ. 2021 он

	хамрагдаагүй өсвөр насны хүүхэд	
6.	Аюулгүй байдал	Аюул, осол, эрсдэл, гэмтэл бэртлээс хамгаалагдаж байх нөхцөл байдал бие махбод, хүрээлэн буй орчин, нийгэм, оюун санаа, улс төр, сэтгэл зүйн хохирлоос ангид байх хүмүүсийн бие махбодын, хувь хүний сайн сайхан, бүрэн, бүтэн байдал. ⁴⁵
6.	Сургууль завсардалт	Өмнөх хичээлийн жилд тодорхой анги, бүлгийн суралцагчид тухайн хичээлийн жилд үргэлжлүүлэн суралцаагүй байвал сургууль завсардалт гэж үзнэ. ⁴⁶
6.	Эцэг, эх, асран хамгаалагчаас тусдаа бие даан амьдарч байгаа хүүхэд	Ерөнхийн боловсролын сургуульд суралцдаг хүүхдүүдээс эцэг, эхийн асран хамгааллаас хол хөндий, бие даан амьдарч байгаа хүүхэд.
6.	Бие даан амьдарч байгаа хүүхэд	ЕБС-д суралцдаг хүүхдүүдээс эцэг, эхийн асран хамгааллаас хол хөндий бие даан амьдарч байгаа хүүхэд.
6.	ЕБС-ийн дотуур байр	ЕБС-д суралцагчид байрлаж, амьдрах зориулалттай байр.
6.	ЕБС-ын дотуур байрны багш	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын багш албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг /бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, багш эсхүл нийгмийн ажилтан мэргэжилтэй, боловсрол судлал, сэтгэл зүй, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн/ хангасан, дотуур байрны хүүхдэд боловсролын болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан.
6.	Шашны сургуульд суралцдаг хүүхэд	Шашны боловсролыг шашны сургууль, гэрийн сургалтаар олгоно. Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцна.
6.	Биеийн тамирын секц, дугуйлан	Хүн амын бие бялдрын хөгжил болон биеийн тамирын хичээлийг дэмжих зорилготой үйл ажиллагаа явуулдаг нэгж, хэсэг.
6.	Урлагийн дугуйлан, уралдаан тэмцээн	Хүүхдийн далд нуугдан буй урлагийн авьяас, ур чадвар, сонирхол, гоо зүйн мэдлэгийг нээн хөгжүүлэх, орчин үеийн дүрслэх болон дизайны урлагийн урсгал, чиглэл, чиг хандлагын талаар ойлголт өгөх, зурж, сэтгэж, урлан бүтээж сургах зорилго бүхий үйл ажиллагааны хэлбэр, төрөл.
6.	Сургуулийн нийгмийн ажилтан	Суралцагч, эцэг эх болон багшийн харилцаа, тэдний нийгмийн асуудлаар үнэлгээ хийх, ганцаарчилсан болон бүлэгт чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, тэдний төлөвшил, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг мэргэжилтэн.
6.	ЕБС-ийн сэтгэл зүйч	Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг /бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, сэтгэл судлалын мэргэжилтэй, боловсролын сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн/ хангасан, суралцагч, багш ажилтанд сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээ, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан.
6.	Стандартад нийцсэн ЕБС-ийн хичээлийн байр	Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг /бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, сэтгэл судлалын мэргэжилтэй, боловсролын сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн/ хангасан, суралцагч, багш ажилтанд сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээ, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан.
6.	ЕБС-ийн стандартад нийцсэн дотуур байр	Стандартын дотуур байрыг стандартчилал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2019 оны тогтоолоор батлагдсан Монгол Улсын MNS 6781:2019 стандарт)-аас

45 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал (нийтлэг шаардлага-5.5). MNS 6948. 2021

46 Боловсролын салбарын статистик үзүүлэлт тооцох аргачлал. ҮСХ. 2013 он

гаргасан стандартыг үндэслэн тогтооно.			
6. Биеийн тамирын заал	Нийгмийн соёлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор оюуны болон материаллаг үнэт зүйлийг бий болгох зорилготой багтаамж бүхий байгууламж. ЕБС-ын биеийн тамирын заалны стандарт хэмжээ 12х24 харьцаатай байна.		
6. Урлагийн заал	Урлагийн тоглолт хийх, хичээллэх, авьяас чадвараа хөгжүүлэх зорилго бүхий байгууламж.		
6. Хүүхдийн чөлөөт цагтаа зарцуулж байгаа цаг	Хүүхэд үүрэг хариуцлага бүхий албан ёсны сургалт хөгжлийн үйл ажиллагаанаас гадна амарч зугаацах, тоглох, хөгжихөд зарцуулж байгаа цаг. Хүүхдийн хоногийн 24 цагаас хэдийг тоглоом болон бусад үйлдлээр чөлөөт цагаа өнгөрөөхөд зарцуулдаг цагаар тодорхойлно. Наад захын чадвар нь "хөтөлбөрийн сорил/суралцах үнэлгээ"-гээр хэмжигдэх бөгөөд суурь мэдлэгийг харьцуулж харуулдаг. Энэ үнэлгээ нь үндэсний болон улс хооронд харилцан адилгүй байдаг. ⁴⁷		
6. Унших болон тоо бодох наад захын чадвар			

47 ТХЗ-ын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. YCX. 2021 он

48 ТХЗ-ын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. YCX. 2021 он

	хийж чадаж байвал тус чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзнэ. Суралцах чадамж: Хүүхэд энгийн зааврын дагуу ямар нэгэн зүйлийг зөв хийж, мөн хийлгэх гэж өгсөн зүйлийг зөв бөгөөд бие даан хийж, гүйцэтгэж байвал суралцах чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзнэ. Хэрэв хүүхэд эдгээрээс наад зах нь нэгийг хийж чадаж байвал тус чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзнэ.
7 ТУСГАЙ ХАМГААЛАЛ	
7. Хараа хяналтгүй хүүхэд	• Эцэг эх буюу хууль ёсны бусад төлөөлөгч, эсвэл албан тушаалтны зүгээс тухайн хүүхдийг хүмүүжүүлэх, сургах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас түүний зан үйлд тавих хяналтгүй болсон хүүхэд.⁴⁹ • Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтаас гарч тэнүүлэн амьдарч байгаа хүүхэд.
7. Насанд хүрээгүй ажилтан	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож байгаа 18 насанд хүрээгүй хүүхдийг ойлгоно. ⁵⁰
7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	Хэт бага наснаасаа ажил хийх, эсвэл бие бялдар, оюун санаа, нийгмийн болон боловсролын хөгжилд нь саад учруулж буй үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үздэг. Судалгааны өмнөх 7 хоногт хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн тоог нийт хүүхдийн тоонд хувааж хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоог гаргана. Энэ үзүүлэлтийг 5-17 насны хүүхдийн хувьд тооцно.⁵¹ Хүүхдийн хөдөлмөрийг дараах нөхцөлийг харгалзан тодорхойлно. Үүнд: - Эдийн засгийн үйл ажиллагаанд дараах цагаас илүү цагаар оролцсон бол • 5-11 нас: 1, түүнээс олон цаг • 12-14 нас: 14, түүнээс олон цаг • 15-17: 43, түүнээс олон цаг - Гэрийн ажлыг дараах цагаас илүү цагаар хийсэн бол • 5-11 болон 12-14 нас: 28, түүнээс олон цаг • 15-17 нас: 43, цаг түүнээс олон цаг - Аюултай нөхцөлд ажилладаг бол • Хэт халуун, хэт чийгтэй, хэт өндөр, хэт тоосжилттой, аюултай тоног төхөөрөмж дээр гэх мэт. - Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад орсон хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд
7. Аюултай ажил эрхэлж байгаа хүүхэд	Хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил; Газар дор, усны гүнд болон аюултай өндөрт эсвэл хэтэрхий давчуу орон зайд хийж буй ажил; Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцаж буй ажил, түүнчлэн хүнд ачааг гараараа өргөж, зөөх болон тээвэрлэх зэрэг биеийн хүчний ажил; Эрүүл бус орчинд, тухайлбал, хүүхдийг аюултай бодис, урвалжтай харьцах, аюултай ажиллавар гүйцэтгэхэд хүргэж буй эсвэл хүүхдийн эрүүл мэндэд хортой байж болох агаарын хэм, дуу чимээ эсвэл чичиргэн бүхий нөхцөлд хийж буй ажил; Тодорхой хүнд нөхцөлд, тухайлбал уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар эсвэл ажил олгогчийн ажлын байранд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хашигдан хийж буй ажил;⁵² зэрэг ажил хийж буй хүүхэд.
7. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд: Боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр

49 Хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь. Хууд. 303. 2018 он

50 Хөдөлмөрийн тухай хууль, 4.1.6 дахь заалт

51 ТХЗ-ын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. ҮСХ. 2021 он

52 Хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь. Хууд. 71. 2018 он

	буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаанууд; Хүүхдийн биеийг үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл тийм үйл ажиллагаанд ашиглах, элсүүлэх эсвэл тийм үйл ажиллагаанд оролцохыг санал болгох; Хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг олон улсын холбогдох гэрээнүүдэд заагдсан хууль бус үйл ажиллагаанд оролцохыг санал болгох; Мөн чанар эсвэл хөдөлмөрийн нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хохирол учруулахуйц хөдөлмөрийг хамааруулна.
7. Хурдан морь уралдаанч хүүхэд	8, түүнээс дээш настай, эрүүл мэндийн байгууллагаас уралдаанд оролцоход эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаангүй гэсэн тодорхойлолт авсан, хурдан морины уралдаанч хүүхдийн ослын даатгалд даатгуулсан хүүхдийг ойлгоно. ⁵³
7. Ядуурал	Ядуурал нь хувь хүний аж байдлын доройтол, хомсдолтой байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавх доройтох, хоол тэжээлийн хомсдол, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэргээр илэрдэг. ⁵⁴
7. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийг ойлгоно. ⁵⁵ Нийгмийн халамжийн сангаас хамгаалал шаардлагатай хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж буй иргэний асаргааны тэтгэмжийг мөн олгодог.
7. Зориулалтын бус сууц	Зориулалтын бус сууц гэж анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан, гэхдээ хүн амьдарч байгаа сууцыг ойлгоно. Жишээлбэл, вагончик, амбаар, пин, агуулах, дэлгүүр, мухлаг зэрэг орно. Бусад сууц гэж хүн амьдарч байгаа, байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад тохиромжгүй байр, талбайг бусад төрөлд хамааруулна. Тухайлбал, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей), ой мод, уул хад, агуй зэрэг орно.
7. Усны чанарын стандарт	Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан усны хими, физик, биологийн шинж чанарын үзүүлэлтүүд нь хүний эрүүл мэнд, усан орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хэм хэмжээг хэлнэ. ⁵⁶
7. Цэвэр түлш	Хоол хийхэд ашигладаг анхдагч түлшийг хатуу болон хатуу бус гэж ангилах бөгөөд хатуу түлшийг агаарыг бохирдуулдаг, орчин үеийн бус гэж үздэг бол хатуу бус түлшийг цэвэр гэж үздэг. ⁵⁷
8 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	
8. 18 хүртэлх насны хүүхдийн өмгөөлөл	Хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэд хуульд заасан өмгөөллийн үйлчилгээг авах эрхтэй. ⁵⁸ Өмгөөллийн үйлчилгээ нь хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой ба холбогдох төрийн байгууллагаас өмгөөллийн үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр тодорхойлогдоно.
8. Шүүхийн шийдвэрээр тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхэд	Тухайн жилд шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаагаар тасалдуулаагүй, тогтмол авдаг хүүхдийг ойлгоно. ⁵⁹

53 Үндэсний их баяр наадмын тухай хууль, 10.2, 10.3, 14.7.8 дахь заалт

54 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. ҮСХ. 2013 он

55 ХЭХТЗС-ийн шалгуур үзүүлэлтийн удирдамж болон үр дүнгийн хүрээ

56 Байгаль орчны статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. ҮСХ. 2019 он

57 ТХЗ-ийн мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. ҮСХ. 2021 он

58 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам. 2020 он

59 Зөрчлийн тухай хууль, 6.20 дугаар зүйл

8. Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан хүүхэд	Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх зэрэг шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/ хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг зэрэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хассан тохиолдлыг ойлгоно. ⁶⁰
8. Хохирогч хүүхэд	Гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн, бие эрхтэн, оюун санааны хувьд үйл ажиллагаа нь алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд эд материалын хохирол хүлээснээ хэрэг бүртгэх байгууллагад бүртгүүлсэн, прокурорт хэрэг нь хянагдсан, гэмт хэргийн улмаас хохирсон болохыг нь шүүгч, прокурор, мөрдөгч тогтоож шийдвэр гаргасан хүүхэд. ⁶¹ Мөн түүнчлэн хэрэг зөрчил гаргагч болон бүлэг гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэл санаа, эд материалын хохирол, гэмтэл авсан, хүний үндсэн эрх нь зөрчигдсөн хүүхэд багтана.
8. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	Монгол Улсын Эрүүгийн хууль болон бусад хууль, тогтоомжийг зөрчиж, хууль, хяналтын байгууллагаар шалгагдан гэм буруутай нь тогтоогдож, аль нэг шатны шүүхийн шийдвэр гарсан хүүхдийн эсрэг гэмт хэргийг хэлнэ.
8. Ял шийтгүүлсэн хүүхэд	Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, ял шийтгэл эдэлж байгаа болон ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй хүүхдийг ойлгоно. ⁶²
8. Гэмт хэргийн гэрч	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.
8. Хоригдож, саатуулагдаж буй хүүхэд	Хэргийн мөрдлөг болон шүүхийн шийдвэрийн өмнө нь цагдаагийн байгууллага, хорих, шийтгэлийн болон засан хүмүүжүүлэх газар зэрэг ямар нэгэн байгууллагад хоригдож байгаа хүүхдийг хэлнэ.
8. Хорих ял	Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ. ⁶³
8. Ял төлөвлөхөөс өмнө хугацаа	Ял төлөвлөхөөс өмнө хоригдсон хугацааг дараах байдлаар бүлэглэнэ. ⁶⁴ • Нэг сар хүртэл хугацаатай хоригдсон • 1-3 хүртэлх сарын хугацаатай хоригдсон • 3-6 хүртэлх сарын хугацаатай хоригдсон • 6-12 хүртэлх сарын хугацаатай хоригдсон • 12-24 хүртэлх сарын хугацаатай хоригдсон • 24-60 хүртэлх сарын хугацаатай хоригдсон • 60-аас дээш сар хугацаатай хоригдсон
8. Хүмүүжлийн арга хэмжээ	Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүмүүжлийн энэ хуулийн 7.3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээг ойлгоно. ⁶⁴
8. Ял хойшлуулах	Ял хойшлуулах гэж анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл зургаан сараас 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулахыг ойлгоно. ⁶⁵
8. Нөхөн сэргээх үйлчилгээ	Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ нь хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалах нөхөн сэргээх, хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд

60 Гэр бүлийн тухай хууль, 30 дугаар зүйл

61 Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал. ҮСХ. 2018 он

62 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

63 Эрүүгийн хууль, 5.6 дахь заалт

64 Эрүүгийн хууль, 8.7 дугаар зүйл

65 Эрүүгийн хууль, 6.7 дугаар зүйл

	хамгаалах нөхөн сэргээх гэсэн хоёр хэлбэртэй байна. Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, эрх бүхий байгууллага нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох дүрэм, журмыг баримтална. ⁶⁶
9 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ЦАХИМ ОРЧИН	
9. Цахим орчин	Цахим (дигитал) орчин гэж байнга хөгжиж, хүрээгээ тэлж байдаг мэдээлэл, харилцаа холбооны технологиуд болох тоон сүлжээ, контент, програмууд, төхөөрөмжүүд, виртуал болон бодит байдлыг дүрсэлсэн орчин, хиймэл оюун ухаан, робот техник, автоматжуулсан систем, алгоритм ба өгөгдлийн аналитик, биометрик болон суулгацын технологиуд зэргийг ойлгоно. ⁶⁷ Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална. ⁶⁸
Цахим гэмт 9. хэргийн улмаас хохирсон хүүхэд	Цахим орчинд хэн нэгэн хүнтэй холбоо тогтоосноос шалтгаалан хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхралт, мөлжлөг, шударга бус, харгис хэрцгий байдлын хохирогч болсон хүүхдийг хэлнэ. ⁶⁹

1 ГАМШИГ, ГАМШГИЙН ОНЦГОЙ БАЙДАЛ

1Г Гамшиг	Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрах үзэгдэл. ⁷⁰
1Г Хариу арга хэмжээ	Гамшиг, онцгой байдлын үед буюу түүний дараа нэн даруй хүний амь насыг аврах, эрүүл мэндэд учрах хор хөнөөлийг бууруулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хүний нэр төрийг хамгаалах, гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргааны наад захын хэрэгцээг хангах зорилгоор үйлчилгээ, тусламж үзүүлнэ. ⁷¹
1Г Гал түймэрт өртсөн хүүхдийн хувь	Хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шаталтыг гал түймэр гэж ойлгоно. ⁷²
1Г Онцгой нөхцөлд байгаа хүүхдийн хувь	Онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж байгалийн гамшиг, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртөхийг ойлгоно. ⁷³
1Г Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдийн тоо	Шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхэд гэж албан эсвэл албан бус шалтгаанаар, тухайн улс орон дотроо эсвэл улс орон хооронд, эцэг эх, асран хамгаалагчийн хамт эсвэл ганцаараа шилжих хөдөлгөөнд оролцсоны улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, ёс суртахуун, оюун ухаан, хөгжилд нь хохирол учирсан, эсхүл хохирол учрах эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ. ⁷² Шилжин суурьшсан газар

66 Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам. ХНХЯ-ны тушаал. 2021 он

67 НҮБ-ын Хүүхдийн хорооноос гаргасан зөвлөмж:

<https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G21/053/43/PDF/G2105343.pdf?OpenElement>

68 Хүүхэд хамгааллын тухай хууль, 8.1 дэх заалт

69 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хамгаалахтай холбоотой нэр томьёоны тайлбар

70 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал (нийтлэг шаардлага-5.15). MNS 6948:2021

71 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал (нийтлэг шаардлага-5.15). MNS 6948:2021

72 НҮБ-ын Шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхдийг хэмжих үнэлгээ хийх аргачлал. 2020

	нутагтаа ядаж 180 ба түүнээс дээш хоногоор оршин сууж байгаа өрхийг “Шилжигч өрх” гэж үзнэ.⁷³ • Дотоод шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхэд • Гадаад орон руу шилжсэн хүүхэд • Эх орондоо эргэж ирсэн хүүхэд • Гадаад орон руу дүрвэсэн хүүхэд
--	--

ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ

1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

- 1.1. Хүүхэд хамгааллын хамтын ажиллагааны байгууллагын тоо
- 1.2. Хүүхэд хамгааллын салбарын хүний нөөц
- 1.3. Мэргэжлийн нийгмийн ажилтны эзлэх хувь
- 1.4. Улсын төсөвт хүүхэд хамгааллын зардлын эзлэх хувь
- 1.5. ДНБ-д хүүхэд хамгааллын зардлын эзлэх хувь
- 1.6. Хүүхдийн асуудлаар гаргасан ИТХ-ын тогтоолын эзлэх хувь
- 1.7. Хүүхдийн асуудлаар гаргасан Засаг даргын захирамжийн эзлэх хувь
- 1.8. Хүүхдээс гарсан саналыг тусгасан ИТХ-ын тогтоолын эзлэх хувь

2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧМЫН ҮЗҮҮЛЭЛТ

- 2.1. Үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртсөн хүүхдийн хувь (ХЭХТЗС 1.7)
- 2.2. Санаатай аллагын хохирогч хүүхдийн түвшин (ТХЗ 16.1.1, ХЭХТЗС 1.9)
- 2.3. Амиа хорлосон хүүхдийн түвшин (ТХЗ 3.4.2)
- 2.4. Хүний эрхийн бие даасан байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлоос шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын эзлэх хувь
- 2.5. Төрснийг нь иргэний бүртгэлийн байгууллага бүртгэсэн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 16.9.1)
- 2.6. Нас сэтгэхүй, танин мэдэхүйн хэрэгцээнд тохирсон номтой 5 хүртэлх насны хүүхдийн хувь

3. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- 3.1. Сүүлийн 12 сард бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 16.1.3)
- 3.2. Сүүлийн нэг сард асран хамгаалагчаасаа сэтгэл санааны болон бие махбодын ямар нэгэн шийтгэл хүлээсэн 1-17 насны хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 16.2.1, ХЭХТЗС 1.1)
- 3.3. Багш сурган хүмүүжүүлэгчийн зүгээс бие махбодын шийтгэл оногдуулсан гэж мэдээлсэн хүүхдийн хувь (ХЭХТЗС 1.2)
- 3.4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн түвшин (ТХЗ 16.2.2)
- 3.5. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн эзлэх хувь
- 3.6. Сүүлийн 12 сарын хугацаанд одоогийн болон өмнөх дотны хамтрагчийн зүгээс бие махбодын, бэлгийн болон/эсвэл сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 15-17 насны охидын эзлэх хувь (ТХЗ 5.2.1) (ХЭХТЗС 1.5)
- 3.7. Хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэл хэрэгтэй гэж үзсэн эцэг, эх, асран хамгаалагчийн хувь (ХЭХТЗС 4.1)
- 3.8. Сургуульд сурч буй хүүхдүүдэд багш нар болон захиргааны ажилтнууд бие махбодын шийтгэл хэрэглэх нь зөв гэдэгтэй санал нийлдэг насанд хүрэгчид болон өсвөр насны хүүхдийн эзлэх хувь (ХЭХТЗС 4.2)
- 3.9. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт хүн амд хүүхдийн эзлэх хувь
- 3.10. 18 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан 18-29 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь (ТХЗ 16.2.3) (ХЭХТЗС 1.3)
- 3.11. Дотны хамтрагчаас бусад этгээдийн зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны охидын хувь (ТХЗ 5.2.2)

4. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан хүүхдийн хувь
- 4.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 4.3. Хувийн хэрэг (кейс) нээсэн хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь
- 4.4. Тухайн жилд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн түвшин
- 4.5. Гэр бүлийн орчинд үзүүлэх хувилбарт үйлчилгээнд шинээр хамруулсан хүүхдийн түвшин
- 4.6. Гэр бүлийн орчинд үзүүлэх хувилбарт үйлчилгээг зогсоосон хүүхдийн түвшин
- 4.7. Тухайн жилд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн түвшин

- 4.8. Төвлөрсөн асрамж халамжийн төвд шинээр хамруулсан хүүхдийн түвшин
- 4.9. Төвлөрсөн асрамж халамжийн төвийн үйлчилгээг зогсоосон хүүхдийн түвшин
- 4.10. Үрчлэгдсэн хүүхдийн түвшин
- 4.11. Улсын хилээр нэвтэрсэн хүүхдийн тоо
- 4.12. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 4.13. Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн эзлэх хувь
- 4.14. Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүүхдийн эзлэх хувь
- 4.15. Эцэг, эхтэйгээ амьдардаг хүүхдийн эзлэх хувь
- 4.16. Эцэгтэйгээ амьдардаг хүүхдийн эзлэх хувь
- 4.17. Эхтэйгээ амьдардаг хүүхдийн эзлэх хувь
- 4.18. Эцэг, эхтэйгээ амьдардаггүй хүүхдийн эзлэх хувь
- 4.19. Хагас болон бүтэн өнчин хүүхдийн эзлэх хувь

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

- 5.1. Эмнэлгийн мэргэжилтний эх барьсан төрөлтийн эзлэх хувь (ТХЗ 3.1.2)
- 5.2. Өсвөр насны охидын жирэмслэлтийн түвшин
- 5.3. Өсвөр насны охидын жирэмслэлтийн эзлэх хувь
- 5.4. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (ТХЗ 3.7.2)
- 5.5. Өсвөр насны охидын төрөлтийн эзлэх хувь
- 5.6. Өсвөр насны охидын үр хөндөлтийн тусгай коэффициент
- 5.7. Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон өсвөр насныхны эзлэх хувь (ТХЗ 5.3.1 ХЭХТЗС 9.5)
- 5.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь
- 5.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зарцуулсан мөнгөн тэтгэмж, тусламжийн хэмжээ
- 5.10. Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь
- 5.11. Сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхдийн эзлэх хувь
- 5.12. Цахим тоглоомд донтсон хүүхдийн эзлэх хувь
- 5.13. Архи, согтууруулах ундаа хэрэглэдэг сурагчдын эзлэх хувь (ХЭХТЗС 9.6)
- 5.14. Тамхи таталтын тархалт (ТХЗ 3.а.1)
- 5.15. Мансууруулах бодис хэрэглэдэг сурагчдын эзлэх хувь
- 5.16. Ахуйн осол гэмтлээс шалтгаалан түлэгдсэн хүүхдийн эзлэх хувь
- 5.17. Осол гэмтэлд өртсөн хүүхдийн эзлэх хувь
- 5.18. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн түвшин
- 5.19. Бэлгийн харилцаа, жирэмслэлтээс сэргийлэх хэрэгсэл хэрэглэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламжийг авах талаар бие дааж шийдвэр гаргадаг 15-19 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь (ТХЗ 5.6.1)
- 5.20. Нярайн эндэгдлийн түвшин (ТХЗ 3.2.2)
- 5.21. Нялхсын эндэгдлийн түвшин
- 5.22. Эхийн эндэгдлийн түвшин
- 5.23. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (ТХЗ 3.2.1)
- 5.24. Насны бүлэг дэх нас баралтын коэффициент
- 5.25. Тав хүртэлх насны туранхай, илүүдэл жинтэй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 2.2.2 а,б)
- 5.26. Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 2.2.1)
- 5.27. Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь
- 5.28. Нэг нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь
- 5.29. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан бүх төрлийн вакцинжуулалтад хамрагдсан зорилтот хүн амын эзлэх хувь (ТХЗ 3.б.1)
- 5.30. Нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын эзлэх хувь
- 5.31. Суулгалт өвчнөөр өвчилж, шингэн сэлбэх давсны уусмал болон цайрын бэлдмэл хэрэглэсэн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь
- 5.32. Уушгины хатгалгааны шинж тэмдэг илэрсэн үед эрүүл мэндийн байгууллага эсвэл эмчээс зөвлөгөө авсан 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь
- 5.33. 10000 хүүхдэд ногдох эмнэлгийн орны тоо
- 5.34. 10000 хүүхдэд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч хүүхдийн түвшин

- 5.35. 10000 хүүхдэд ногдох хүүхдийн эмчийн тоо (ТХЗ 3.с.1)
- 5.36. Жирэмсэн үед ХДХВ-ний халдвар эхээс хүүхдэд дамжих эрсдэлийг бууруулах зорилгоор ретровирусний эсрэг эмчилгээнд хамрагдсан ХДХВ-ний халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- 5.37. Жирэмсний хяналтын хувь
- 5.38. 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- 5.39. Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа 0-5 сартай хүүхдийн эзлэх хувь
- 5.40. Амьсгалын замын цочмог халдварын шинж илэрсэн хүүхдийн эзлэх хувь
- 5.41. Хүүхдээ эхийн сүүгээр хооллож байсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- 5.42. Төрсний дараа 1 цагийн дотор амлуулсан нярайн эзлэх хувь
- 5.43. Бага жинтэй төрөлтийн эзлэх хувь
- 5.44. Цус багадалттай 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь
- 5.45. Өвчний ангиллаар тооцсон хүүхдийн нас баралтын түвшин
- 5.46. Халдваргүй 1000 хүнд ногдох тухайн жилд ХДХВ-ийн халдвар авсан хүүхдийн тоо (ТХЗ 3.3.1)
- 5.47. Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин (ТХЗ 3.9.1)

6. БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

- 6.1. Бага насны хүүхдийн хөгжлийн индекс
- 6.2. СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн тоо
- 6.3. СӨБ-ын хамран сургалтын бохир жин
- 6.4. ЕБС-ийн хамран сургалтын цэвэр жин
- 6.5. СӨБ-д ажиллаж байгаа нэг багшид ногдох хүүхдийн тоо
- 6.6. ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь
- 6.7. СӨБ-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь
- 6.8. Анги дүүргэлтийн түвшин
- 6.9. ЕБС-д суралцдаг, сургуульдаа хичээлээс гадуур дугуйланд хамрагддаг хүүхдийн эзлэх хувь
- 6.10. Эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн байгууламжтай сургалтын байгууллагын эзлэх хувь (ТХЗ 4.а.1)
- 6.11. Боловсролын үзүүлэлтээр тооцсон "Тэгш байдлын" индекс (ТХЗ 4.5.1)
- 6.12. Суралцаагүй, хөдөлмөр эрхлээгүй, сургалтад хамрагдаагүй өсвөр насны хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 8.6.1)
- 6.13. Сургууль завсардалтын хувийн жин (ХЭХТЗС 9.2)
- 6.14. ЕБС-д суралцдаг түр хугацаагаар айлд амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь
- 6.15. ЕБС-д суралцдаг бие даан амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь
- 6.16. ЕБС-ийн дотуур байранд хамрагдалтын хувь
- 6.17. Дотуур байрны нэг багшид ногдох хүүхдийн тоо
- 6.18. Шашны сургуульд суралцаж буй хүүхдийн эзлэх хувь
- 6.19. ЕБС-д суралцдаг бүтэн өнчин хүүхдийн түвшин
- 6.20. Зохион байгуулалттай сургалтад хамрагдалтын хувь (сургуульд элсэн орохын өмнөх 1 жилд) (ТХЗ 4.2.2)
- 6.21. Сургуулийн гадна байгаа хүүхдийн тоо
- 6.22. Бага, дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа
- 6.23. Биеийн тамирын секц дугуйланд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 6.24. Урлагийн дугуйлан, уралдаан тэмцээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 6.25. ЕБС-д ажиллаж байгаа нэг эмчид ногдох хүүхдийн тоо
- 6.26. ЕБС-д ажиллаж байгаа нэг нийгмийн ажилтанд ногдох хүүхдийн тоо
- 6.27. ЕБС-д ажиллаж байгаа нэг сэтгэл зүйчид ногдох хүүхдийн тоо
- 6.28. ЕБС-ийн стандартад нийцсэн хичээлийн байрны эзлэх хувь
- 6.29. ЕБС-ийн стандартад нийцсэн дотуур байрны эзлэх хувь
- 6.30. Биеийн тамирын заалтай сургуулийн эзлэх хувь
- 6.31. Урлагийн заалтай сургуулийн эзлэх хувь
- 6.32. Хүүхдийн чөлөөт цагтаа зарцуулж байгаа цаг

- 6.34. Хүүхдийн хичээл давтахад зарцуулж байгаа цаг
- 6.35. Хүүхдийн ном уншихад зарцуулж байгаа цаг
- 6.36. Стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайн эзлэх хувь
- 6.37. Биеийн тамир, спортын заал талбайн тоо
- 6.38. Хүүхдийн зусланд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 6.39. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 6.40. Унших болон тоо бодох наад захын чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 4.1.1)
- 6.41. Эрүүл мэндийн байдал, сэтгэх суралцах чадвар, нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн зохих түвшинд байгаа 36-59 сартай хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 4.2.1)

7. ТУСГАЙ ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

- 7.1. Хараа хяналтгүй хүүхдийн эзлэх хувь
- 7.2. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 8.7.1)
- 7.3. Аюултай ажил эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь
- 7.4. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь
- 7.5. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс хөндийрсөн хүүхдийн эзлэх хувь
- 7.6. Хурдан морь унаач хүүхдийн эзлэх хувь
- 7.7. Үндэсний ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхөд амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 1.2.1, ХЭХТЗС 7.1)
- 7.8. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 1.3.1, ХЭХТЗС 7.4)
- 7.9. Цалин хөлсгүйгээр гэрийн ажилд туслах, хүн асрах ажилд зарцуулсан 7 хоногийн дундаж цаг
- 7.10. Зориулалтын бус болон бусад сууцанд амьдардаг өрхийн хүүхдийн эзлэх хувь
- 7.11. Аюулгүй байдлаар зохион байгуулагдсан ундны усны үйлчилгээ авдаг өрхөд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 6.1.1)
- 7.12. Эрүүл ахуйн шаардлага хангасан АЦБ-аар хангагдсан, ус болон саван бүхий гар угаах зориулалтын газартай хүн амын эзлэх хувь (ТХЗ 6.2.1)
- 7.13. Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг өрхөд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 7.1.2)

8. ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

- 8.1. 18 хүртэлх насны хүүхдийн өмгөөлөлд төрөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ
- 8.2. Шүүхийн шийдвэрээр тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн эзлэх хувь
- 8.3. Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан хүүхдийн эзлэх хувь
- 8.4. Албан ёсоор гэр бүл цуцлуулсан, хүүхэдтэй гэр бүлийн эзлэх хувь
- 8.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт хүүхдийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь
- 8.6. Шүүхээр шийдвэрлүүлсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь
- 8.7. Гэмт хэргийн гэрч хүүхдийн түвшин
- 8.8. Гэмт хэргийн хохирогч хүүхдийн түвшин
- 8.9. Ял шийтгүүлсэн хүүхдийн эзлэх хувь
- 8.10. Хоригдож, саатуулагдаж буй хүүхдийн түвшин (ХЭХТЗС 8.9)
- 8.11. Хорих ангид ял эдэлж буй хүүхдийн түвшин
- 8.12. Хорих ангид хоригдох ял авсан хүүхдийн эзлэх хувь
- 8.13. Ял оногдуулахаас өөр хүмүүжлийн арга хэмжээ авсан хүүхдийн хувь
- 8.14. Ял хойшлуулсан хүүхдийн эзлэх хувь
- 8.15. Хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан хорих ангиас суллагдсан хүүхдийн хувь

9. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

- 9.1. Сүүлийн 12 сарын хугацаанд интернэт хэрэглэсэн хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 17.8.1)
- 9.2. Цахим гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эзлэх хувь
- 9.3. Танихгүй хүнтэй цахим орчинд харилцсан хүүхдийн хувь (ХЭХТЗС 5.3)

9.4. Цахим орчинд анх танилцсан хүнтэйгээ биечлэн уулзсан хүүхдийн эзлэх хувь (ХЭХТЗС 5.4)

10. ГАМШИГ, ГАМШГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ҮЗҮҮЛЭЛТ

10.1. Гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон болон гамшигт шууд нэрвэгдсэн хүүхдийн тоо (ТХЗ 1.5.1)

10.2. Гамшиг, гамшгийн онцгой байдлын үед хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн эзлэх хувь

10.3. Гал түймэрт өртсөн хүүхдийн эзлэх хувь

10.4. Онцгой нөхцөл байдалд байгаа хүүхдийн эзлэх хувь

10.5. Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдийн эзлэх хувь

СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

Хүүхэд хамгааллын хамтын ажиллагааны байгууллагын тоо

Тооцох арга зүй: Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн, төрийн бус болон олон улсын байгууллага зэрэг хуулийн этгээдийн нийт тоогоор илэрхийлэгдэнэ.

$$ХХБТ = ХХТБ + ХХТББ + ХХОУ$$

ХХБТ- Хүүхэд хамгааллын байгууллагын тоо

ХХТБ- Хүүхэд хамгааллын төрийн байгууллагын тоо

ХХТББ- Хүүхэд хамгааллын төрийн бус байгууллагын тоо

ХХОУ- Хүүхэд хамгааллын олон улсын байгууллагын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хуулийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр

Мэдээллийн задар

гаа: Улс, бүс, аймаг, нийслэл, хуулийн этгээдийн төрөл, өмчийн хэлбэрээр

Хүүхэд хамгааллын тогтолцооны хүний нөөц

Тооцох арга зүй: Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын хүүхэд хамгааллын ажиллагчид болон бусад салбарын хүүхэд хамгааллын ажиллагчдын нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

$$ХХТА = ГБХЗСА + БСХХА$$

ХХТА- Хүүхэд хамгааллын тогтолцооны ажиллагчид

ГБХЗСА- Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын хүүхэд хамгааллын ажиллагчид

БСХХА- Бусад салбарын хүүхэд хамгааллын ажиллагчид

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг нийслэл, сум, дүүрэг, хороо, нас, хүйс, ажилласан жил, мэргэжлийн зэрэг, салбараар

Мэргэжлийн нийгмийн ажилтны эзлэх хувь

Тооцох арга зүй: Мэргэжлийн ажлын диплом, гэрчилгээтэй нийгмийн ажилтны тоог нийт нийгмийн ажилтны тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$MHA_{(хувь)} = \frac{MDГНАТ}{HНАТ} * 100$$

MHA - Мэргэжлийн нийгмийн ажилтны эзлэх хувь

MDГНАТ - Мэргэжлийн диплом, гэрчилгээтэй нийгмийн ажилтны тоо

HНАТ - Нийт нийгмийн ажилтны тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг нийслэл, сум, дүүрэг, хороо, мэргэжлийн түвшин, боловсролын зэргээр

Улсын төсвийн зардалд хүүхэд хамгааллын зардлын эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүүхэд хамгааллын салбарт улсын төсвөөс зарцуулсан зардлыг улсын төсвийн нийт зардалд харьцуулж, хувиар илэрхийлнэ. Хүүхэд хамгааллын санхүүжилтэд хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв болон хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг ойлгоно.

$$УТХХЗ_{(хувь)} = \frac{ХХСЗ}{УТНЗ} * 100$$

УТХХЗ-Улсын төсөвт хүүхэд хамгааллын зардлын эзлэх хувь

ХХСЗ- Хүүхэд хамгааллын салбарын зардал

УТНЗ- Улсын төсвийн нийт зардал

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг нийслэл, сум, дүүрэг, хороогоор

Дотоодын нийт бүтээгдэхүүнд хүүхэд хамгааллын зардлын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд зарцуулсан хүүхэд хамгааллын нийт зардлыг тухайн оны дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ДНБЭХХСЗ_{(хувь)} = \frac{ХХНЗ}{ДНБ} * 100$$

ДНБЭХХСЗ- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хүүхэд хамгааллын салбарын эзлэх зардал

ХХНЗ- Хүүхэд хамгааллын нийт зардал

ДНБ-Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, Дотоодын нийт бүтээгдэхүүний гүйцэтгэл, жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэлээр

Хүүхэдтэй холбоотой гаргасан ИТХ-ын тогтоолын эзлэх хувь

Тооцох арга: Бүх шатны ИТХ-аас хүүхэдтэй холбоотой гаргасан тогтоолын тоог нийт тогтоолын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХХГИТХТХ_{(хувь)} = \frac{ХХГИТХТТ}{НТТ} * 100$$

ХХГИТХТХ- Хүүхэдтэй холбоотой гаргасан ИТХ-ын тогтоолын эзлэх хувь
ХХГИТХТТ- Хүүхэдтэй холбоотой гаргасан ИТХ-ын тогтоолын тоо
НТТ- Нийт тогтоолын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр

Хүүхдийн асуудлаар гаргасан Засаг даргын захирамжийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүүхэдтэй холбоотой асуудлаар бүх шатны Засаг даргын гаргасан захирамжийн тоог нийт захирамжийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ХАГЗДЗ}_{(\text{хувь})} = \frac{\text{ХАГЗДЗТ}}{\text{НЗТ}} * 100$$

ХАГЗДЗ_(хувь) – Хүүхдийн асуудлаар гаргасан Засаг даргын захирамжийн эзлэх хувь
ХАГЗДЗТ – Хүүхдийн асуудлаар гаргасан Засаг даргын захирамжийн тоо
НЗТ- Нийт захирамжийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүргээр

Хүүхдээс гарсан саналыг тусгасан ИТХ-ын тогтоолын эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүүхэд, өсвөр үеийнхний гаргасан саналыг тусгасан ИТХ-ын тогтоолын тоог хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлаар ИТХ-аас гарсан нийт тогтоолын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ХГСТИТХТ}_{(\text{хувь})} = \frac{\text{ХГСТИТХТТ}}{\text{ИТХТНТ}} * 100$$

ХГСТИТХТХ- Хүүхдээс гарсан саналыг тусгасан ИТХ-ын тогтоолын эзлэх хувь
ХГСТИТХТТ- Хүүхдээс гарсан саналыг тусгасан ИТХ-ын тогтоолын тоо
ИТХТНТ- ИТХ-ын тогтоолын нийт тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧМЫН ҮЗҮҮЛЭЛТ

Үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртсөн хүүхдийн эзлэх хувь (ХЭХТЗС 1.7)

Тооцох арга зүй: Сүүлийн 12 сарын байдлаар үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртсөн 11-17 насны хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ҮТХДӨХХ}_{(\text{хувь})} = \frac{\text{ХДӨХТ}_{(11-17 \text{ нас})}}{\text{ХТ}_{(11-17 \text{ нас})}} * 100$$

ҮТХДӨХХ- Үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртсөн хүүхдийн эзлэх хувь

ХДӨХТ- Хүчирхийлэл, дээрэлхэх үзэгдэлд өртсөн талаар асуултад хариулсан хүүхдийн тоо

ХТ_(11-17 нас) – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр (108 дуудлагын утасны мэдээлэл), жил бүр, Тусгайлсан судалгаа, тухай бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, дээрэлхэлтийн төрлөөр (биечлэн/цахим орчинд)

Санаатай аллагын хохирогч хүүхдийн түвшин (ТХЗ 16.1.1)

Тооцох арга зүй: Тухайн жилд бүртгэгдсэн санаатай аллагын гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 100000-аар үржүүлж илэрхийлнэ.

$$CAXX_{(100\ 000\ хүнд\ ногдох)} = \frac{CAXXT_{(18\ хүртэлх\ нас)}}{ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100\ 000$$

CAXX_(100 000 хүнд ногдох) – Санаатай аллагын хохирогч хүүхдийн түвшин

CAXXT_(18 хүртэлх нас) – Санаатай аллагын хохирогч хүүхдийн тоо

ХТ_(18 хүртэлх нас) – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, байршил (хот, хөдөө), аллагын хэлбэрээр

Амиа хорлож, нас барсан хүүхдийн түвшин (ТХЗ 3.4.2)

Тооцох арга зүй: Амиа хорлосон нь шүүхээр тогтоогдсон хүүхдийн тоог тухайн насны МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж илэрхийлнэ.

$$AXH BX_{(10\ 000\ хүүхдэд\ ногдох)} = \frac{AXXT}{ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 10\ 000$$

AXH BX_(10 000 хүнд ногдох) – Амиа хорлож, нас барсан хүүхдийн түвшин

AXH BXТ – Амиа хорлож, нас барсан хүүхдийн тоо

ХТ_(18 хүртэлх нас) – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-ийн мэдээ, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, байршил (хот, хөдөө), шалтгаанаар

Хүний эрхийн бие даасан байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлоос шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайлант хугацаанд шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоог бүртгэгдсэн нийт өргөдөл, гомдлын тоонд харьцуулж, 100-аар үржүүлж илэрхийлнэ.

$$ШӨГ_{(хувь)} = \frac{ШӨГТ}{БӨГТ} * 100$$

ШӨГ_(хувь) – Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын эзлэх хувь

ШӨГТ – Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо

БӨГТ- Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өргөдөл, гомдлын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Өргөдөл, гомдлын тайлан (ХЭҮК), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, шалтгаанаар

Төрснийг нь иргэний бүртгэлийн байгууллага бүртгэсэн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 16.9.1)

Тооцох арга зүй: Төрснийг нь харьяа иргэний бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн 5 хүртэлх насны хүүхдийн тоог МУ-д оршин суугаа тухайн насны хүүхдийн жилийн дундаж тоонд хувааж, хувиар илэрхийлнэ.

$$ИБББХ_{(хувь)} = \frac{ТИБББХТ_{(5 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(5 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ИБББХ_(хувь) – Иргэний бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хүүхдийн эзлэх хувь
ТИБББХТ_(5 хүртэлх нас) – Төрснийг нь иргэний бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хүүхдийн тоо
ХТ_(5 хүртэлх нас) – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын тооллого, 10 жил тутам, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 5 жил тутам (ҮСХ), Иргэний бүртгэлийн төрөлтийн мэдээллийн системийн мэдээлэл, жил бүр
Мэдээллийн задаргаа: Нас, хүйс, өрхийн аж байдал, газар зүйн байршлаар

Нас сэтгэхүй, танин мэдэхүйн хэрэгцээнд тохирсон номтой 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Нас сэтгэхүй, танин мэдэхүйн хэрэгцээнд тохирсон номтой 5 хүртэлх насны хүүхдийн тоог МУ-д оршин суугаа тухайн насны хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$НСТМХТНХ_{(хувь)} = \frac{НСТМХТНХТ}{ХТ_{(0-5 \text{ нас})}} * 100$$

НСТМХТНХ - Нас сэтгэхүй, танин мэдэхүйн хэрэгцээнд тохирсон номтой 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь
НСТМХТНХТ - Нас сэтгэхүй, танин мэдэхүйн хэрэгцээнд тохирсон номтой 5 хүртэлх насны хүүхдийн тоо
ХТ_(0-5 нас) – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар (ҮСХ) 5 жил тутам
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, насны бүлэг, хүйс, хөгжлийн бэрхшээл, өрхийн аж байдлаар

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Сүүлийн 12 сард бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 16.1.3)

Тооцох арга зүй: Сүүлийн 12 сарын хугацаанд бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хохирогч хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$БМССБХӨХХ_{(хувь)} = \frac{БМССБХӨХХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

БМССБХӨХХ_(хувь) - бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хохирогч хүүхдийн эзлэх хувь

БМССБХӨХХТ_(18 хүртэлх нас) - бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хохирогч хүүхдийн тоо

ХТ_(18 хүртэлх нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэмт хэргийн болон эрүүл мэндийн тайлан (ЦЕГ, ЭМЯ), жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа (ЖСХС), Зорилтот болон тусгайлсан судалгаа, тухай бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, байршил (хот/хөдөө), хөгжлийн бэрхшээл, хүчирхийллийн хэлбэрээр

Сүүлийн нэг сард асран хамгаалагчаасаа сэтгэл санааны болон бие махбодын ямар нэгэн шийтгэл хүлээсэн 1-17 насны хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 16.2.1; ХЭХТЗС 1.1)

Тооцох арга зүй: Сүүлийн нэг сард эцэг, эх/асран хамгаалагчийн зүгээс бие махбодын шийтгэл хүлээж, сэтгэл зүйн дарамтад орсон 1-17 насны хүүхдийн тоог МУ-д оршин суугаа 1-17 насны нийт хүүхдийн тоонд хувааж, 100-аар үржүүлнэ.

$$ШХХ_{(хувь)} = \frac{ШХХТ_{(1-17 \text{ нас})}}{ХТ_{(1-17 \text{ нас})}} * 100$$

ШХХ_(хувь) - Шийтгэл хүлээсэн хүүхдийн эзлэх хувь

ШХХТ_(1-17 нас) - Шийтгэл хүлээсэн хүүхдийн тоо

ХТ_(1-17 нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: НҮТС (ҮСХ), 5 жил тутам, Гэмт хэргийн болон эрүүл мэндийн тайлан (ЦЕГ, ЭМЯ) жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, байршил (хот/хөдөө), хөгжлийн бэрхшээл, хүчирхийллийн хэлбэрээр

Багш, сурган хүмүүжүүлэгчийн зүгээс бие махбодын шийтгэл оногдуулсан гэж мэдээлсэн хүүхдийн эзлэх хувь (ХЭХТЗС 1.2)

Тооцох арга зүй: Багш, сурган хүмүүжүүлэгчийн зүгээс бие махбодын шийтгэл хүлээсэн гэж хариулсан өсвөр насны хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 100-аар үржүүлж илэрхийлнэ.

$$БМШХХ_{(хувь)} = \frac{БМШХХТ_{(12-17 \text{ нас})}}{ХТ_{(12-17 \text{ нас})}} * 100$$

БМШХХ_(хувь) - Багш сурган хүмүүжүүлэгчийн зүгээс бие махбодын шийтгэл хүлээсэн хүүхдийн эзлэх хувь

БМШХХТ_(12-17 нас) - Багш сурган хүмүүжүүлэгчийн зүгээс бие махбодын шийтгэл хүлээсэн хүүхдийн тоо

ХТ_(12-17 нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Тусгайлсан судалгаа, тухай бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, сургууль, нас, хүйс, байршил (хот/хөдөө), хөгжлийн бэрхшээл, шилжих хөдөлгөөн, шийтгэлийн хэлбэрээр

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн түвшин (ТХЗ 16.2.2)

Тооцох арга зүй: Тухайн жилд бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 100000-аар үржүүлнэ.

$$XXГХХХ_{(100\ 000\ хүнд\ ногдох)} = \frac{XXГХХХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100\ 000$$

*XXГХХХ*_(100 000 хүнд ногдох) - Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн түвшин

*XXГХХХТ*_(18 хүртэлх нас) - Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоо

*ХТ*_(18 хүртэлх нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэмт хэргийн тайлан (ЦЕГ), жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, байршил (хот/хөдөө), хөгжлийн бэрхшээл, хүчирхийллийн хэлбэр, мөлжлөгийн хэлбэрээр

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Нийт хүүхдээс бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн эзлэх хувиар илэрхийлэгдэнэ.

$$БМӨХ_{(хувь)} = \frac{БМӨХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100$$

*БМӨХ*_(хувь) - Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн эзлэх хувь

*БМӨХТ*_(18 хүртэлх нас) - Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо

*ХТ*_(18 хүртэлх нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэмт хэргийн тайлан (ЦЕГ), жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байршил, нас, хүйс, мөлжлөгийн хэлбэрээр

Сүүлийн 12 сарын хугацаанд одоогийн болон өмнөх дотны хамтрагчийн зүгээс бие махбодын, бэлгийн болон/эсвэл сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 15-17 насны охидын эзлэх хувь (ТХЗ 5.2.1, ХЭХТЗС 1.5)

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байршил, ЕБС-ийн өмчийн хэлбэрээр

ЕБС-ийн стандартад нийцсэн дотуур байрны эзлэх хувь

Тооцох арга зүй: ЕБС-ийн стандартад нийцсэн дотуур байрны тоог нийт дотуур байрны тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$CHDB_{(хувь)} = \frac{CHDBT}{ДБТ} * 100$$

$CHDB_{(хувь)}$ – ЕБС-ын стандартад нийцсэн дотуур байрны эзлэх хувь
 $CHDBT$ – ЕБС-ын стандартад нийцсэн дотуур байрны тоо
 $ДБТ$ – ЕБС-ийн нийт дотуур байрны тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (БШУЯ)

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, байршил, ЕБС-ийн өмчийн хэлбэрээр

Биеийн тамирын заалтай сургуулийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Биеийн тамирын заалтай ЕБС-ийн тоог нийт ЕБС-ийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$БТЗЕБС_{(хувь)} = \frac{БТЗЕБСТ}{ЕБСТ} * 100$$

БТЗЕБС_(хувь) – Биеийн тамирын заалтай ЕБС-ын эзлэх хувь
БТЗЕБСТ – Биеийн тамирын заалтай ЕБС-ийн тоо
ЕБСТ – ЕБС-ийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (БШУЯ)

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байршил, ЕБС-ийн өмчийн хэлбэрээр

Урлагийн заал, танхимтай сургуулийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Урлагийн заалтай ЕБС-ийн хичээлийн байрны тоог нийт ЕБС-ийн хичээлийн байрны тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$УЗЕБС_{(хувь)} = \frac{УЗЕБСТ}{ЕБСТ} * 100$$

УЗЕБС_(хувь) – Урлагийн заал, танхимтай ЕБС-ын эзлэх хувь
УЗЕБСТ – Урлагийн заал, танхимтай сургуулийн тоо
ЕБСТ – ЕБС-ийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (БШУЯ)

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байршил, ЕБС-ийн өмчийн хэлбэрээр

Хүүхдийн чөлөөт цагтаа зарцуулж байгаа цаг

Тооцох арга зүй: 12-17 насны хүүхдийн тоглоом болон бусад үйлдлээр чөлөөт цагаа өнгөрөөхөд зарцуулсан нийт цагийг гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ЦАС (ҮСХ), 4 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, насны бүлэг, хүйс, сургуульд хамрагдалт, орон сууцны төрлөөр

Хүүхдийн телевиз үзэхэд зарцуулж байгаа цаг

Тооцох арга зүй: 12-17 насны хүүхдийн телевиз үзэхэд зарцуулсан нийт цагийг гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ЦАС (ҮСХ), 4 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, насны бүлэг, хүйс, сургуульд хамрагдалт, орон сууцны төрлөөр

Хүүхдийн хичээл давтахад зарцуулж байгаа цаг

Тооцох арга зүй: 12-17 насны хүүхдийн хичээлээ давтахад зарцуулсан нийт цагийг гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ЦАС (ҮСХ), 4 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, насны бүлэг, хүйс, сургуульд хамрагдалт, орон сууцны төрлөөр

Хүүхдийн ном уншихад зарцуулж байгаа цаг

Тооцох арга зүй: 12-17 насны хүүхдийн ном уншихад зарцуулсан нийт цагийг гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ЦАС (ҮСХ), 4 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, насны бүлэг, хүйс, сургуульд хамрагдалт, орон сууцны төрлөөр

Стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайн эзлэх хувь

Тооцох арга зүй: Стандартад нийцсэн тоглоомын талбайн тоог нийт тоглоомын талбайн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$CHXTT_{(хувь)} = \frac{CHXTTT}{TTT} * 100$$

$CHXTT_{(хувь)}$ – Стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайн эзлэх хувь

$CHXTTT$ – Стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайн тоо

TTT – Хүүхдийн тоглоомын талбайн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ХНХЯ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр

Биеийн тамир, спортын заал талбайн тоо

Тооцох арга зүй: Биеийн тамир, спортын заал талбайн тоогоор илэрхийлнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Биеийн тамирын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (БТСУХ,) жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр

Хүүхдийн зусланд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд хүүхдийн зусланд амарсан хүүхдийн тоог, МУ-д оршин суугаа тухайн насны хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 100-аар үржүүлнэ.

$$X3XX_{(хувь)} = \frac{X3XHT_{(18 \text{ хүртэлх нас})}}{HT_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

$X3XX_{(хувь)}$ – Хүүхдийн зусланд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь

$X3XHT_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Тухайн жилд зусланд амарсан хүүхдийн тоо

$HT_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Тухайн насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ХНХЯ), жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, дүүрэг, насны бүлэг, давтамжаар

Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан 2-5 насны хүүхдийн тоог, тухайн насны хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$XXYXX_{(хувь)} = \frac{XXYXXT_{(2-5 \text{ нас})}}{XT_{(2-5 \text{ нас})}} * 100$$

$XXYXX_{(хувь)}$ – Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
 $XXYXXT_{(2-5 \text{ нас})}$ – Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан 2-5 насны хүүхдийн тоо
 $XT_{(2-5 \text{ нас})}$ – 2-5 насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ХНХЯ), жил бүр, Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, насны бүлэг, хүйсээр

Унших болон тоо бодох наад захын чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 4.1.1)

Тооцох арга зүй:

1. Тухайн анги/шатанд суралцдаг унших наад захын чадварыг эзэмшсэн хүүхдийн тоог тухайн анги/шатанд суралцаж байгаа нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$УЧЭХХ_i = \frac{УЧНХТ_i \text{ бүлэг}}{ХТ_i \text{ бүлэг}} * 100$$

$УЧЭХХ_i$ – Унших чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь
 $УЧНХТ_i \text{ бүлэг}$ – Унших чадвартай нийт хүүхдийн тоо
 $ХТ_i \text{ бүлэг}$ – Нийт хүүхдийн тоо

2. Тухайн анги/шатанд суралцдаг тоо бодох наад захын чадварыг эзэмшсэн хүүхдийн тоог тухайн анги/шатанд суралцаж байгаа нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ТБЧЭХХ_i = \frac{ТБЧНХТ_i \text{ бүлэг}}{ХТ_i \text{ бүлэг}} * 100$$

$ТБЧЭХХ_i$ – Тоо бодох чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь
 $ТБЧНХТ_i \text{ бүлэг}$ – Тоо бодох чадвартай нийт хүүхдийн тоо
 $ХТ_i \text{ бүлэг}$ – Нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: НҮТС (ҮСХ), 5 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, нас, хүйс, унших болон тоо бодох чадвар, хөгжлийн бэрхшээл, ангиар

Эрүүл мэндийн байдал, сэтгэх суралцах чадвар, нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн зохих түвшинд байгаа 36-59 сартай хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 4.2.1)

Тооцох арга зүй: Хүүхдийн хөгжлийн наад захын чадваруудын аль нэг 3 чадвартай гэж тодорхойдогдсон 36-59 сартай хүүхдийн тоог нийт 36-59 сартай хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХХЗТХ_{(хувь)} = \frac{ХХНЗЧХТ_{(36-59 \text{ сар})}}{ХТ_{(36-59 \text{ сар})}} * 100$$

$ХХЗТХ_{(хувь)}$ – Хүүхдийн хөгжлийн зохих түвшинд байгаа хүүхдийн эзлэх хувь
 $ХХНЗЧХТ_{(36-59 \text{ сар})}$ – Хүүхдийн хөгжлийн наад захын чадвартай хүүхдийн тоо

$ХТ_{(36-59 \text{ сар})}$ - Нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: НҮТС (ҮСХ), 5 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, өрхийн аж байдал, эцэг эхийн боловсролоор

ТУСГАЙ ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Хараа хяналтгүй хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд бүртгэгдсэн хараа хяналтгүй хүүхдийн тоог, тухайн насны нийт хүн амд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$XXX_{(хувь)} = \frac{БХХХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

$XXX_{(хувь)}$ - Хараа хяналтгүй хүүхдийн эзлэх хувь

$БХХХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ - Бүртгэгдсэн хараа хяналтгүй хүүхдийн тоо

$ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ХНХЯ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, гэр бүлийн байдал, шалтгаан (төөрсөн, оргосон, хүчирхийлэлд өртсөн)-аар

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ-ын 8.7.1)

Тооцох арга зүй: Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоог нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХЭБХ_{(хувь)} = \frac{ХЭБХТ_{(5-17 \text{ нас})}}{ХТ_{(5-17 \text{ нас})}} * 100$$

$ХЭБХ_{(хувь)}$ - Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь

$ХЭБХТ_{(5-17 \text{ нас})}$ - Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо

$ХТ_{(5-17 \text{ нас})}$ - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ХХС (ҮСХ), тухай бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, нас, хүйс, сургуульд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлтийн байдал, ЭЗБТҮАСА, ажил мэргэжлийн ангиллаар

Аюултай ажил эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Аюултай ажил эрхэлж байгаа хүүхдийн тоог нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ААЭХ_{(хувь)} = \frac{ААЭХТ_{(5-17 \text{ нас})}}{ХТ_{(5-17 \text{ нас})}} * 100$$

$ААЭХ_{(хувь)}$ - Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь

$ААЭХТ_{(5-17 \text{ нас})}$ - Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн тоо

$ХТ_{(5-17 \text{ нас})}$ - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ХХС (ҮСХ), тухай бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, байршил, нас, хүйс, сургуульд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлтийн байдал, ЭЗБТҮАСА, ажил мэргэжлийн ангиллаар

Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоог нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ТХХЭХ_{(хувь)} = \frac{ТХХЭХТ_{(5-17 \text{ нас})}}{ХТ_{(5-17 \text{ нас})}} * 100$$

ТХХЭХ_(хувь) - Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь
ТХХЭХТ_(5-17 нас) - Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо
ХТ_(5-17 нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Тусгайлсан түүвэр судалгаа, тухай бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, байршил, ЭЗБТҮАСА, ажил, мэргжлийн ангилал, нас, хүйсээр

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс хөндийрсөн хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээ зогсоосон хүүхдийн тоог тухайн жилд хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХЭЗХ_{(хувь)} = \frac{ХЭЗХТ_{(5-17 \text{ нас})}}{ХЭНХТ_{(5-17 \text{ нас})}} * 100$$

ХЭЗХ_(хувь) - Хөдөлмөр эрхлэлтээ зогсоосон хүүхдийн эзлэх хувь
ХЭЗХТ_(5-17 нас) - Хөдөлмөр эрхлэлтээ зогсоосон хүүхдийн тоо
ХЭНХТ_(5-17 нас) - Тухайн жилийн хөдөлмөр эрхэлсэн нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Тусгайлсан түүвэр судалгаа, тухай бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, байршил, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, холбон зуучилсан үйлчилгээгээр

Хурдан морь унаач хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жил улсын баяр наадам, шигшмэл, бүсийн уралдаан болон аливаа хэлбэрийн хурдан морины бэлтгэл үе шат (үсэргээ, сунгаа) уралдаанд оролцсон уяач хүүхдийн тоог тухайн насны хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХМУХ_{(хувь)} = \frac{ХМУХТ_{(7-17 \text{ нас})}}{ХТ_{(7-17 \text{ нас})}} * 100$$

ХМУХ_(хувь) - Хурдан морь унаач хүүхдийн эзлэх хувь
ХМУХТ_(7-17 нас) - Аливаа хэлбэрийн хурдан морины бэлтгэл үе болон уралдаанд оролцсон унаач хүүхдийн тоо
ХТ_(7-17 нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ХНХЯ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, давтамж, бэртсэн эсэх, даатгалтай эсэх, уралдааны хэлбэрээр

Үндэсний ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 1.2.1)

Тооцох арга зүй: Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоог нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$Y\dot{A}ШДХ\dot{O}A\dot{X}_{(хувь)} = \frac{Y\dot{A}ШДХ\dot{O}A\dot{X}_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

Y\dot{A}ШДХ\dot{O}A\dot{X}_{(хувь)} - Үндэсний ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхөд амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь

Y\dot{A}ШДХ\dot{O}A\dot{X}_{(18 \text{ хүртэлх нас})} - Үндэсний ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхөд

амьдарч байгаа хүүхдийн тоо

ХТ_{(18 \text{ хүртэлх нас})} - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ӨНЭЗС (ҮСХ), 2 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, байршил, нас, хүйсээр

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 1.3.1)

Тооцох арга зүй: Тухайн жилд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхдийн тоог 0-17 насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$H\dot{X}Y\dot{X}X_{(хувь)} = \frac{H\dot{X}Y\dot{A}\dot{O}A\dot{X}_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

H\dot{X}Y\dot{X}X_{(хувь)} - Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн эзлэх хувь

H\dot{X}Y\dot{A}\dot{O}A\dot{X}_{(18 \text{ хүртэлх нас})} - Аливаа төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээ авсан өрхөд амьдарч буй хүүхдийн тоо

ХТ_{(18 \text{ хүртэлх нас})} - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр, ӨНЭЗС (ҮСХ), 2 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, халамжийн үйлчилгээний төрлөөр

Цалин хөлсгүйгээр гэрийн ажилд туслах, хүн асрах ажилд зарцуулсан 7 хоногийн дундаж цаг

Тооцох арга зүй: 5-17 насны хүүхдийн 7 хоногт гэрийн ажил болон хүн асрах ажилд зарцуулсан нийт цагийг гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: НҮТС (ҮСХ), 5 жил тутам, ХХС (ҮСХ), тухай бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, байршил, нас, хүйсээр

Зориулалтын бус болон бусад сууцанд амьдардаг өрхийн хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Зориулалтын бус болон бусад сууцанд амьдардаг өрхийн хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ЗБСА\dot{O}X_{(хувь)} = \frac{ЗБСА\dot{O}X_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ЗБСА\dot{O}X_{(хувь)} – Зориулалтын бус болон бусад сууцанд амьдардаг өрхийн хүүхдийн эзлэх хувь

ЗБСА\dot{O}X_{(18 \text{ хүртэлх нас})} - Зориулалтын бус болон бусад сууцанд амьдардаг өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо

ХТ_(18 хүртэлх нас) - МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ХАОСТ (ҮСХ), 10 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хүүхдийн нас, хүйс, сургуульд хамрагдалтын байдлаар

Аюулгүй байдлаар зохион байгуулагдсан ундны усны үйлчилгээ авдаг өрхөд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 6.1.1)

Тооцох арга зүй: Хүн ам, орон сууцны тооллого, өрхөд суурилсан түүвэр судалгаагаар өрхийн ундны усны эх үүсвэр болон эх үүсвэр нь хаана байршиж байгаа талаарх мэдээллийн үр дүнгээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ХАОСТ (ҮСХ), 10 жил тутам, НҮТС (ҮСХ), 5 жил тутам
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, өрхийн аж байдлаар

Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан, ус болон саван бүхий гар угаах зориулалтын газартай хүн амын эзлэх хувь (ТХЗ 6.2.1)

Тооцох арга зүй: Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан, ус болон саван бүхий гар угаах зориулалтын газартай хүн амын хувийг тооцохдоо ариун цэврийн янз бүрийн байгууламж ашигладаг хүн амын хувь болон ялгадсыг нь зохистой байдлаар зайлуулдаг хүн амын хувийг нэгтгэн тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ХАОСТ (ҮСХ), 10 жил тутам, НҮТС (ҮСХ), 5 жил тутам
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, өрхийн аж байдлаар

Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг өрхөд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь (ТХЗ 7.1.2)

Тооцох арга зүй: Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг өрхөд амьдарч буй хүүхдийн хувиар илэрхийлэгдэнэ.

$$ЦТТХӨХ_{(хувь)} = \frac{ЦТТХӨХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{СХӨХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ЦТТХӨХ_(хувь) – Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг өрхөд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь

ЦТТХӨХТ_(18 хүртэлх нас) – Цэвэр түлш, технологийг хэрэглэдэг өрхөд амьдарч буй хүүхдийн тоо

СХӨХТ_(18 хүртэлх нас) – Судалгаанд хамрагдсан өрхөд амьдарч буй хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: НҮТС (ҮСХ), 5 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, аймаг, нийслэл, өрхийн аж байдлаар

ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

18 хүртэлх насны хүүхдийн өмгөөлөлд төрөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ

Тооцох арга зүй: Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүүхдийн өмгөөллийн үйлчилгээнд тухайн жилд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн нийт дүнгээр тодорхойлно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, Хуулийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэлээр

Шүүхийн шийдвэрээр хүүхдийн тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Шүүхийн шийдвэрээр хүүхдийн тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн тоог тэтгэлэг авах шаардлагатай нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ШШТТАХ}_{(\text{хувь})} = \frac{\text{ХТТАХТ}_{(18 \text{ хүртэлх нас})}}{\text{ТАШНХТ}_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ШШТТАХ_(хувь) – Шүүхийн шийдвэрээр тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн эзлэх хувь
ХТТАХТ_(18 хүртэлх нас) – Хүүхдийн тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн тоо
ТАШНХТ_(18 хүртэлх нас) – Тэтгэлэг авах шаардлагатай нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ШШГЕГ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, байршил, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр

Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан нийт хүүхдийн тоог нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ЭЭЭЭБЭХХ}_{(\text{хувь})} = \frac{\text{ЭЭЭЭБЭХХТ}_{(18 \text{ хүртэлх нас})}}{\text{ХТ}_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ЭЭЭЭБЭХХ_(хувь) – Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан хүүхдийн эзлэх хувь
ЭЭЭЭБЭХХТ_(18 хүртэлх нас) – Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан хүүхдийн тоо
ХТ_(18 хүртэлх нас) – Нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, шалтгаанаар

Албан ёсоор гэр бүл цуцлуулсан, хүүхэдтэй гэр бүлийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Гэр бүл цуцлуулсан, хүүхэдтэй гэр бүлийн тоог албан ёсоор гэрлэлтээ цуцлуулсан нийт гэр бүлийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ГБЦХГБ}_{(\text{хувь})} = \frac{\text{ГБЦХГБТ}}{\text{ГБЦНГБ}} * 100$$

ГБЦХГБ_(хувь) – Албан ёсоор гэр бүл цуцлуулсан, хүүхэдтэй гэр бүлийн эзлэх хувь
ГБЦХГБТ – Албан ёсоор гэр бүл цуцлуулсан хүүхэдтэй гэр бүлийн тоо
ГБЦНГБ – Гэр бүл цуцлуулсан нийт гэр бүлийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Иргэний бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, жил бүр, Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хүүхдийн тоогоор

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт хүүхдийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоог бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХЭГХ_{(хувь)} = \frac{ХЭГХТ}{НБГХТ} * 100$$

ХЭГХ_(хувь) – Бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт хүүхдийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь

ХЭГХТ – Хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо

НБГХТ – Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байршил, гэмт хэргийн төрөл, үйлдсэн байдлаар (биеэр, цахимаар)

Шүүхээр шийдвэрлүүлсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Шүүхээр шийдвэрлүүлсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоог хүүхдийн эсрэг нийт гэмт хэргийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ШШХЭГХ = \frac{ШШХЭГХТ}{НБГХТ} * 100$$

ШШХЭГХ_(хувь) – Шүүхээр шийдвэрлүүлсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь

ШШХЭГХТ – Шүүхээр шийдвэрлүүлсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо

НБГХТ – Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр, Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, гэмт хэргийн төрлөөр

Гэмт хэргийн гэрч хүүхдийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн гэрч хүүхдийн тоог тухайн насны МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 100000-аар үржүүлж илэрхийлнэ.

$$ГХГХТ_{(100\ 000\ хүүхдэд\ ногдох)} = \frac{БГХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100\ 000$$

ГХГХТ_{(100\ 000\ хүүхдэд\ ногдох)}} – Гэмт хэргийн гэрч хүүхдийн түвшин

БГХТ_{(18\ хүртэлх\ нас)}} – Тухайн жил бүртгэгдсэн гэрч хүүхдийн тоо

ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} – Жилийн дундаж хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр
 Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, асаргааны хэлбэр (гэр бүлийн, асрах газрын, тэнэмэл зэрэг), эцэг, эх, асран хамгаалагчийн нийгмийн байдлаар

Гэмт хэргийн хохирогч хүүхдийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоог тухайн насны МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, 100000-аар үржүүлж илэрхийлнэ.

$$ГХХХТ_{(100\ 000\ хүүхдэд\ ногдох)} = \frac{БГХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100\ 000$$

ГХХХТ_(100 000 хүүхдэд ногдох) – Гэмт хэргийн хохирогч хүүхдийн түвшин
БХХТ_(18 хүртэлх нас) – Тухайн жил бүртгэгдсэн хохирогч хүүхдийн тоо
ХТ_(18 хүртэлх нас) – Жилийн дундаж хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр
 Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээл, гэмт хэргийн төрлөөр

Ял шийтгүүлсэн хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Шүүхээс ял шийтгүүлсэн хүүхдийн нийт тоог, тухайн жилд гэмт хэрэгт холбогдсон нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ШЯШОХ_{(хувь)} = \frac{ШЯШОХТ}{ГХХНХТ} * 100$$

ШЯШОХ_(хувь) – Шүүхээс ял шийтгэл оногдуулсан хүүхдийн эзлэх хувь
ШЯШОХТ – Тухайн жилд шүүхээс ял шийтгэл оногдуулсан хүүхдийн тоо
ГХХНХТ – Тухайн жилд гэмт хэрэгт холбогдсон нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
 Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, гэмт хэргийн төрлөөр

Хоригдож, саатуулагдаж буй хүүхдийн түвшин (ХЭХТЗС 8.9)

Тооцох арга зүй: Тухайн жилд хоригдож, саатуулагдаж байгаа нийт хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 100000 үржүүлж илэрхийлнэ.

$$ХСХТ_{(100\ 000\ хүүхдэд\ ногдох)} = \frac{ХСНХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ХА_{(18\ хүртэлх\ нас)}} * 100\ 000$$

ХСХТ_(100 000 хүүхдэд ногдох) – Хоригдож, саатуулагдаж буй хүүхдийн түвшин
ХСНХТ_(18 хүртэлх нас) – Тухайн жилд хоригдож, саатуулагдаж байсан нийт хүүхдийн тоо
ХА_(18 хүртэлх нас) – Тухайн жилийн дундаж хүн амын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, шалтгаанаар

Хорих ангид ял эдэлж байгаа хүүхдийн түвшин

Тооцох арга зүй: Хорих ангид ял эдэлж байгаа хүүхдийн нийт тоог нийт хүүхдийн тоонд харьцуулж, 100000-аар үржүүлж илэрхийлнэ.

$$ХАЯЭБХ_{(100\ 000\ хүүхдэд\ ногдох)} = \frac{ХАЯЭБХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ГХХНХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100\ 000$$

$ХАЯЭБХ_{(100\ 000\ хүүхдэд\ ногдох)}$ – Хорих ангид ял эдэлж байгаа хүүхдийн түвшин
 $ХАЯЭБХТ_{(18\ хүртэлх\ нас)}$ – Тухайн жилд хорих ангид ял эдэлж байгаа хүүхдийн тоо
 $ГХХНХТ_{(18\ хүртэлх\ нас)}$ – Тухайн жилд гэмт хэрэгт холбогдсон нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, гэмт хэргийн төрөл, давтамжаар

Хорих ангид хоригдох ял авсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хорих ангид хоригдох ял авсан хүүхдийн тоог шүүхээс ял шийтгүүлсэн нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХАХЯАХ_{(хувь)} = \frac{ХАХЯАХТ_{(15-17\ нас)}}{ШЯШХТ_{(15-17\ нас)}} * 100$$

$ХАХЯАХ_{(хувь)}$ – Хорих ангид хоригдох ял авсан хүүхдийн эзлэх хувь
 $ХАХЯАХТ_{(15-17\ нас)}$ – Хорих ангид хоригдох ял авсан хүүхдийн тоо
 $ШЯШХТ_{(15-17\ нас)}$ – Тухайн жилийн дундаж хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, гэмт хэргийн төрөл, давтамжаар

Ял оногдуулахаас өөр хүмүүжлийн арга хэмжээ авсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоог нийт ял шийтгэл авсан болон хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХАХХХ_{(хувь)} = \frac{ХАХХХТ_{(18\ хүртэлх\ нас)}}{ШХТ_{(18\ хүртэлх\ нас)}} * 100$$

$ХАХХХ_{(хувь)}$ – Ял оногдуулахаас өөр хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
 $ХАХХХТ_{(18\ хүртэлх\ нас)}$ – Хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо
 $ШХТ_{(18\ хүртэлх\ нас)}$ – Нийт шийтгэл авсан хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр: Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, байршил, шийтгэлийн төрлөөр

Ял хойшлуулсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Ял хойшлуулсан хүүхдийн тоог ял шийтгүүлсэн нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ЯХХ_{(хувь)} = \frac{ЯХХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ЯШХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

$ЯХХ_{(хувь)}$ – Ял хойшлуулсан хүүхдийн эзлэх хувь

$ЯХХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Ял хойшлуулсан хүүхдийн тоо

$ЯШХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Ял шийтгүүлсэн нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, гэмт хэргийн төрөл, давтамжаар

Хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан хорих ангиас суллагдсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жил хорих ангид ял эдэлж байгаад суллагдаж, нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхдийн тоог хорих ангиас суллагдсан хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХЗХҮХХ_{(хувь)} = \frac{НСҮАХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХАСХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

$ХЗХҮХХ_{(хувь)}$ – Хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан хорих ангиас суллагдсан хүүхдийн эзлэх хувь

$НСҮАХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Хорих ангид ял эдэлж байгаад суллагдаж, нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхдийн тоо

$ХАСХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Хорих ангиас суллагдсан хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр: Шүүхийн статистикийн тайлан (ШЕЗ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, байршил, нөхөн сэргээх үйлчилгээний төрлөөр

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Сүүлийн 12 сарын хугацаанд интернэт хэрэглэсэн хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга: Сүүлийн 12 сарын хугацаанд интернэт хэрэглэсэн 15-17 насны хүүхдийн тоог МУ-д оршин суугаа тухайн насны хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ИХХ_{(хувь)} = \frac{ИХХТ_{(15-17 \text{ нас})}}{ХТ_{(15-17 \text{ нас})}} * 100$$

$ИХХ_{(хувь)}$ – Интернэт хэрэглэсэн хүүхдийн эзлэх хувь

$ИХХТ_{(15-17 \text{ нас})}$ – Интернэт хэрэглэсэн хүүхдийн тоо

$ХТ_{(15-17 \text{ нас})}$ – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: НҮТС (ҮСХ), 5 жил тутам

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, хот, хөдөө, нас, хүйс, сургуульд хамрагдалтын байдал, өрхийн аж байдлаар

Цахим гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга: Цахим гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоог гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ЦГХУХХХ}_{(\text{хувь})} = \frac{\text{ЦГХУХХТ}_{(15-17 \text{ нас})}}{\text{ГХУХХТ}_{(15-17 \text{ нас})}} * 100$$

$\text{ЦГХУХХ}_{(\text{хувь})}$ – Цахим гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эзлэх хувь
 $\text{ЦГХУХХТ}_{(15-17 \text{ нас})}$ – Цахим гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо
 $\text{ГХУХХТ}_{(15-17 \text{ нас})}$ – Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Гэмт хэргийн мэдээ (ЦЕГ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, асаргааны хэлбэр, эцэг, эх, асран хамгаалагчийн нийгмийн байдал, хөгжлийн бэрхшээлээр

Танихгүй хүнтэй цахим орчинд харилцсан хүүхдийн эзлэх хувь (ХЭХТЗС 5.3)

Тооцох арга: Сүүлийн 12 сарын хугацаанд өмнө огт уулзаж байгаагүй хүнтэй цахим орчинд харилцаж байсан гэж хариулсан хүүхдийн тоог судалгаанд оролцсон хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ТХЦОХХ}_{(\text{хувь})} = \frac{\text{ТХЦОХХТ}_{(15-17 \text{ нас})}}{\text{СХХТ}_{(15-17 \text{ нас})}} * 100$$

$\text{ТХЦОХХ}_{(\text{хувь})}$ – Танихгүй хүнтэй цахим орчинд харилцсан хүүхдийн эзлэх хувь
 $\text{ТХЦОХХТ}_{(15-17 \text{ нас})}$ – Танихгүй хүнтэй цахим орчинд харилцсан хүүхдийн тоо
 $\text{СХХТ}_{(15-17 \text{ нас})}$ – Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Тусгайлсан судалгаа, тухай бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, хот, хөдөө, нас, хүйс, сургуульд хамрагдалтын байдал, хөгжлийн бэрхшээлээр

Цахим орчинд анх танилцсан хүнтэйгээ биечлэн уулзсан хүүхдийн эзлэх хувь (ХЭХТЗС 5.4)

Тооцох арга: Сүүлийн 12 сарын хугацаанд цахим орчинд анх танилцсан хүнтэй биечлэн уулзсан хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\text{ЦОТХУХ}_{(\text{хувь})} = \frac{\text{ЦОТХУХТ}_{(15-17 \text{ нас})}}{\text{ХТ}_{(15-17 \text{ нас})}} * 100$$

$\text{ЦОТХУХ}_{(\text{хувь})}$ – Цахим орчинд анх танилцсан хүнтэй уулзсан хүүхдийн эзлэх хувь
 $\text{ЦОТХУХТ}_{(15-17 \text{ нас})}$ – Цахим орчинд анх танилцсан хүнтэй уулзсан хүүхдийн тоо
 $\text{ХТ}_{(15-17 \text{ нас})}$ – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Тусгайлсан судалгаа, тухай бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, хот, хөдөө, нас, хүйс, сургуульд хамрагдалтын байдал, хөгжлийн бэрхшээлээр

ГАМШИГ, ГАМШГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон болон гамшигт шууд нэрвэгдсэн хүүхдийн тоо (ТХЗ 1.5.1)

Тооцох арга: Тайлант онд гамшгийн улмаас нас барсан, сураггүй болсон, шууд өртсөн хүний тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн эцсийн тоонд хувааж, 100000-аар үржүүлж илэрхийлнэ.

$$НБАБГ_{(18 \text{ хүртэлх нас})} = \frac{ГУНБ_{(18 \text{ хүртэлх нас})} + ГУСБ_{(18 \text{ хүртэлх нас})} + ГШӨ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100\,000$$

НБАБГ_(18 хүртэлх нас) – Гамшгийн улмаас нас барсан, сураггүй болсон болон гамшигт шууд өртсөн 100000 хүнд ногдох хүүхдийн тоо

ГУНБ_(18 хүртэлх нас) – Гамшгийн улмаас нас барсан хүний тоо

ГУСБ_(18 хүртэлх нас) – Гамшгийн улмаас сураггүй болсон хүний тоо

ГШӨ_(18 хүртэлх нас) – Гамшигт шууд өртсөн хүний тоо

МУХТ_(18 хүртэлх нас) – МУ-д оршин суугаа жилийн эцсийн хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын жилийн эцсийн мэдээ (ҮСХ), жил бүр, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ОБЕГ), жил бүр
Мэдээллийн задаргаа: Улс, бүс, хот, хөдөө, нас, хүйс, аюулт үзэгдэл, гамшгийн төрлөөр

Гамшиг, гамшгийн онцгой байдлын үед хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга: Хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоог гамшиг, гамшгийн онцгой байдалд өртсөн хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ХҮАХ_{(хувь)} = \frac{ХҮАХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ГОБӨХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ХҮАХ_(хувь) – Гамшиг, онцгой байдлын үед хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн эзлэх хувь

ХҮАХТ_(18 хүртэлх нас) – Хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо

ГОБӨХТ_(18 хүртэлх нас) – Гамшиг, гамшгийн онцгой байдалд өртсөн хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ОБЕГ), жил бүр

Мэдээллийн задаргаа: Улс, бүс, хот, хөдөө, нас, хүйс, үйлчилгээний төрлөөр

Гал түймэрт өртсөн хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд гал түймэрт өртсөн хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ГТӨХ_{(хувь)} = \frac{ГТӨХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

ГТӨХ_(хувь) – Гал түймэрт өртсөн хүүхдийн эзлэх хувь

$ГТӨХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Гал түймэрт өртсөн хүүхдийн тоо
 $ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ОБЕГ), жил бүр
 Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, сууцны төрлөөр

Онцгой нөхцөлд байгаа хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Онцгой нөхцөлд байгаа нийт хүүхдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ОНБХ_{(хувь)} = \frac{ОНБХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

$ОНБХ_{(хувь)}$ – Онцгой нөхцөлд байгаа хүүхдийн эзлэх хувь
 $ОНБХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Онцгой нөхцөлд байгаа хүүхдийн тоо
 $ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (ОБЕГ), жил бүр
 Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйсээр

Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхдийг тооцохдоо нийт шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхдүүдийн тоог МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$ШХОХ_{(хувь)} = \frac{ШХОХТ_{(18 \text{ хүртэлх нас})}}{ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}} * 100$$

$ШХОХ_{(хувь)}$ – Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдийн эзлэх хувь
 $ШХОХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдийн тоо
 $ХТ_{(18 \text{ хүртэлх нас})}$ – МУ-д оршин суугаа хүүхдийн жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ (УБЕГ), жил бүр, ХАОСТ (ҮСХ), 10 жил тутам
 Мэдээллийн задаргаа: Улс, аймаг, нийслэл, нас, хүйс, гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээлээр

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц
2. МУ-ын Хүүхдийн эрхийн тухай хууль
3. МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хууль
4. МУ-ын Гэр бүлийн тухай хууль
5. МУ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
6. МУ-ын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
7. МУ-ын Зөрчлийн тухай хууль
8. МУ-ын Иргэний улсын бүртгэлийн тухай хууль
9. МУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
10. МУ-ын Нийгмийн халамжийн тухай хууль
11. МУ-ын Статистикийн тухай хууль
12. МУ-ын Тамхины хяналтын тухай хууль
13. МУ-ын Төсвийн тухай хууль
14. МУ-ын Үндэсний их баяр наадмын тухай хууль
15. МУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
16. МУ-ын Хөдөлмөрийн тухай хууль
17. МУ-ын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
18. МУ-ын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль
19. МУ-ын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
20. МУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
21. МУ-ын Эрүүгийн хууль
22. МУ-ын Эрүүл мэндийн тухай хууль
23. ТХЗ-ын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. 2021 он
24. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам
25. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам
26. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа. 2018 он.
27. Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл.
28. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хамгаалахтай холбоотой нэр томъёоны тайлбар
29. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5852:2017
30. Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлт тооцох аргачлал. 2021
31. ХЭХТЗС-ийн шалгуур үзүүлэлтийн удирдамж болон үр дүнгийн хүрээ
32. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээний шаардлага (MNS 6948:2021)
33. НҮБ-ын Шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхдийг хэмжих үнэлгээ хийх аргачлал. 2020

--- оОо ---